# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9

— Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль

— Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль

— Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль

— Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
1997 ОН

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 9-р сар №9 /64/


## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


1. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай 781
2. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 782
3. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай 782
4. Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 783
5. Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 783
5. Монгол Улсын Их Хурлын Хуралдааны дэгийн хуульд өөрчлөлт оруулах тухай 784
7. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 784
8. Гэрээ соёрхон батлах тухай 785
9. Конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай 786
0. Гэрээ соёрхон батлах тухай 786
1 Конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай 787
2 Конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай 787


### 2. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


3 Зарим шүүхийн шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай №14 788
4 Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай №15 788
5 Шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай №16 789
6 Зөвшөөрөл олгох тухай №17 789


### 3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ


7. Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн зарим заалтыг зөрчсөн тухай №02 790
8. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3

дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай №02 792
19. Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хорооны 1997 оны 03 тоот тогтоол Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай №03 798
20. Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 тоот тогтоолын 1 дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг явуулсан байдал нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар №04 801
21. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай №05 806
22. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай №06 808

## 4. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

23. Ан агнуурын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай №271 811

## 5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

24. Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай №152 813
25. Журам батлах тухай №153 826
26. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих ялдлыг журамлах тухай №154 830
27. Сургалтын байгууллагын бүтэц, ажиллагчдын орон тоог оновчтой болгох зарим арга хэмжээний тухай №156 831
28. Улс төрийн зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай №158 839
29. Зарим хүмүүсийг Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай №159 840
30. Хөтөлбөр батлах тухай №160 841
31. Хилийн заагийг тогтоох тухай №162 887
32. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай №164 888
33. Хувьчлах объектын жагсаалт батлах тухай №165 899
34. Дүрэм батлах тухай №166 901

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 23 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ."

2/ 29[1] дүгээр зүйл:

"29[1] дүгээр зүйл. Албадан дуудлага худалдаа зохион байгуулах, гүйцэтгэх

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага нь шүүхийн шийдвэрийн дагуу хураагдсан үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг зохион байгуулна.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага нь шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагатай тохиролцон албадан дуудлага худалдаа явагдах газар, цаг, хугацаа, үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хэмжээ, зориулалт, анхны үнэ болон холбогдох бусад мэдээллийг дуудлага худалдаа эхлэхээс 1 сарын өмнө нийтэд зарлан мэдэгдэнэ.

3. Албадан дуудлага худалдаагаар борлогдох эд хөрөнгийн анхны үнийг төлбөр төлөгч, төлбөр авагч талууд тохиролцон тогтоож болно. Хэрвээ талууд харилцан тохиролцож чадаагүй бол үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагаас томилогдсон хөндлөнгийн инженерийн саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

4. Албадан дуудлага худалдааг эрхлэх хөтлөгчийг шүүхийн шийдвэр биелүүлэх газар, тасаг, хэсгийн дарга томилно.

5. Хөтлөгчөөс үл хөдлөх эд хөрөнгө худалдах анхны үнийг зарласнаар албадан дуудлага худалдаа эхэлсэнд тооцно.

6. Албадан дуудлагын анхны худалдаагаар борлогдоогүй үл хөдлөх эд хөрөнгийг хоёр дахь дуудлага худалдаанд оруулж шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр өмнөх дуудлага худалдааны анхны үнийг 50 хүртэл хувиар бууруулж болно.

7. 50 хүртэл хувиар буурсан үнээр зарагдаагүй бол үл хөдлөх эд хөрөнгийг гуравдахь дуудлага худалдаагаар худалдаална. Энэ

тохиолдолд уг үл хөдлөх эд хөрөнгийг тухайн албадан дуудлага худалдааны хамгийн дээд үнээр худалдана.

8. Албадан дуудлага худалдааны явцад шүүхийн шийдвэр биелүүлэх газар, тасаг, хэсгийн даргаас томилсон нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, түүнд хөтлөгч, худалдан авагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна."

3/ 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"6/үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн төлбөрийн чадварыг харгалзан үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагын саналаар 1 жил хүргэл"

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... шийдвэр гүйцэтгэгч нь ..." гэсний дараа "үл хөдлөх эд хөрөнгөөс бусад" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 2О дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтын "улсын статистик" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 164 дүгээр зүйлийн "хорин таван мянгаас тавин мянга" гэснийг "тавин мянгаас хоёр зуун мянга" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Хүн ам, эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтан, аж ахуйн нэгжийн үлсын тооллого явуулах, бүртгэх ажлаас зайлсхийсэн, эсхүл тооллого, судалгаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, түүнчлэн эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтныг тооллогоос нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох албан тушаалтан, иргэнийг 20000-100000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

**2 дугаар зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "20000" гэснийг "10000-50000" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

997 оны 7 дугаар арын 4-ний өдөр — Улаанбаатар хот

### ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан гуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/ $17^2$ дугаар зүйл:

"$17^2$ дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэхэд түүний үнийн дүнгийн О,О1 хувиар бодож хураамж хураана."

2/ 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/төрөөс хуульд заасан журмын дагуу хувьчлан авсан орон сууцыг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэхэд."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 2, 4, 5, 6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Төрийн байгуулалтын байнгын хороо" гэснийг "Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо" гэж, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3, 5 дахь доголын "Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо" гэснийг "Төсвийн байнгын хороо" гэж тус тус өөрчилсугэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5 Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, олон улсын байгууллага, гадаадын байгууллага болон аж ахуйн нэгж нь Монгол Улсын иргэнийг ажиллуулж байгаа бол түүний нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх

хэсэг, 16 дугаар зүйлийн 1,2,3,4 дэх хэсэгт заасан хувь хэмжээ, журмын дагуу тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын байгууллагад төлнө."

2/ 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь нийгмийн даатгалын төв байгууллага /Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар/, орон нутгийн салбар, нэгж /төлөөлөгч, байцаагч/-ээс бүрдэнэ."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр — Улаанбаатар хот

## ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл** Монгол Улс, Япон Улсын Далайн чанад дахь Эдийн засгийн хамтын ажиллагааны сангийн хооронд 1995 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Улаанбаатар хотын IY дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн төслийн зээлийн Гэрээ"; Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 1995 оны 5 дугаар сарын 17-ны өдөр, Монгол Улс, Нордикийн хөгжлийн сангийн хооронд 1995 оны 3 дугаар сарын 3-ны өдөр тус тус байгуулсан "Эрчим хүчний эргэлзээн босголтын төслийн зээлийн Гэрээ"; Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 1995 оны 12 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан "Авто зам хөгжүүлэх зээлийн Гэрээ"; Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 1995 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр байгуулсан "Агаарын навигацыг хөгжүүлэх зээлийн Гэрээ"-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу тус тус соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Улаанбаатар хот

### КОНВЕНЦИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1980 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Вена хотноо байгуулсан "Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай НҮБ-ын Конвенц"-ийг хүлээн зөвшөөрч нэгдэн орсугай.

**2 дугаар зүйл.** Уг Конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан Монгол Улс "Бараа худалдах, худалдан авах гэрээ, талуудын Хэлэлцээрээр, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, цуцлалт, гэрээний төсөл, түүнийг зөвшөөрөх буюу санал зоригийн бусад илэрхийллийг бичгийн бус аливаа хэлбэрээр хийх боломжоо олгож буй Конвенцийн 11, 29 дүгээр зүйлүүд болон 2 дугаар хэсгийн аливаа заалтыг аль нэг тал нь Монгол Улсад үйлдвэрийн газартай байвал үл мөрдөнө" гэдгийг шийдвэрлэсэн болохыг мэдэгдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Улаанбаатар хот

### ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1997 оны 6 дугаар сарын 9-ний өдөр Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд байгуулсан "Өмнөговь аймгийн Даланзадгад суманд дулааны цахилгаан станц барих төслийн талаархи зээлийн Гэрээ"-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлагсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Улаанбаатар хот

### КОНВЕНЦИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1968 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Вена хотноо байгуулсан "Замын хөдөлгөөний тухай Конвенц"-ийг хүлээн зөвшөөрч нэгдэн орсугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү Конвенцийн 46 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу олон улсын замын хөдөлгөөнд оролцож буй Монгол Улсын тээврийн хэрэгсэлд "MGL" гэсэн ялгах тэмдгийг сонгон авч байгааг мэдэгдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Улаанбаатар хот

### КОНВЕНЦИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1968 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Вена хотноо байгуулсан "Замын дохио, тэмдгийн тухай Конвенц"-ийг хүлээн зөвшөөрч нэгдэн орсугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү Конвенцийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу замын "Анхааруулах тэмдэг"-ийн "Аа", "Зогсохгүй явах хориотой" тэмдгийн "В, 2 а" хэлбэрийг сонгон авч байгааг мэдэгдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот |

**Зарим шүүхийн шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Цэвээндоогийн Өрнөндэлгэрийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Готовдоржийн Цаганцоожийг Ховд аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Бадам-Оргийн Рэнчинтогмидыг Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн, Ичинхорлоогийн Атарбямбыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Нямын Алтангэрэлийг Дорнод аймгийн хэсгийн эрдын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот |

**Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Сүнжидмаагийн Оюунцэцэгийг Дундговь аймгийн шүүхийн шүүгчээр, Цэвээндоогийн Өрнөндэлгэрийг Орхон аймгийн шүүхийн шүүгчээр, Готовдоржийн Цаганцоожийг Ховд аймгийн шүүхийн шүүгчээр Шаравын Оюунхандыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчээр, Тойдонгийн Даваасүрэнг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Сүрэнхорын Амар, Бэгзийн Аминчимэг нарыг Говь-Сүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Цэрэндоржийн Жамбалсүрэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Паламын Мөнхтөрийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Хишигтийн Мөнхжаргалыг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Санжаажавын Дорждагвыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчээр, Наянбуугийн Чулуунжавыг Төв аймаг дахь сум дундын

дүгээр шүүхийн шүүгчээр, Гэндэнжавын Пагмыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Гэндэнжавын Пагмыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Агваны Базарсадыг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Дашзэгвийн Доржхандыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот |

**Шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Шарав овогтой Оюунхандыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот |

**Зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 4,5 дахь заалт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1997 оны 34 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Пүрэвдорж овогтой Сарантуяа, Бадамцоо овогтой Идэрчулуун нарыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, тэднийг эрүүгийн хариуцлагад татсан өдрөөс эхлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гаргах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 3 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн зарим заалтыг зөрчсөн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүн Л.Баасан, Н.Жанцан, Ж.Бямбаа /илтгэгч/, С.Жанцан, Д.Чилхаажав, Ж.Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүү оролцуулан хийв.

Хуралдаанаас нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7,9 дүгээр хорооны иргэн Г.Ганболд, М.Амарсайхан болон Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны иргэн Д.Дашцэдэн нарын гомдлоор үүсгэн Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т байгаа холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Д.Дашцэдэн, М.Амарсайхан, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Батчулуун, Э.Бат-Үүл, мөн Ерөнхий сайдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Сугар нар оролцов.

Иргэн Г.Ганболд, Д.Дашцэдэн, М.Амарсайхан нар Үндсэн хуулийн Цэцэд гаргасан өргөдөлдөө "Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхсайхан 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр захирамж гаргаж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хуулийн дагуу нэр дэвшээгүй хүнийг хамгийн олон санал авсан гэдгээр Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилж, Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т заасан холбогдох заалт зөрчсөнийг шударга ёсны үүднээс хянан үзэж, шүүн хэлэлцэж өгнө үү" гэжээ.

Энэхүү өргөдлийн дагуу Үндсэн хуулийн Цэц маргаан үүсгэж хянан хэлэлцээд "Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль ёсоор нэр дэвшүүлж санал болгоогүй байхад Ж.Наранцацралтыг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн "Засаг даргыг тухайн аймаг, нийслэлийн ... Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд ... 4 жилийн хугацаагаар томилно" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд уламжилжээ.

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг авч хэлэлцсэн Улсын Их Хурал 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолдоо "Засаг даргын үүрэг гүйцэтгэгч томилсон тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 10 тоот дүгнэлтийг "... аймаг, нийслэлийн Засаг даргыг томилох тухай ..." асуудлыг зохицуулсан Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай холбогдолгүй байна" гэсэн үндэслэл заан, хүлээн авах боломжгүй гэж үзжээ.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд нэхэмжлэгчээр оролцсон иргэн Д.Дашцэдэн, М.Амарсайхан нар "Бид нэхэмжлэлээ буцааж авахгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 1997 оны захирамж гарч, урьдах нь үйлчлэхээ больсон. Улсын Их Хурал үндсэн хуулийн Цэцийн хууль зүйн үндэслэл бүхий 10 тоот дүгнэлтийг хүлээж авахгүй байх учиргүй. Дүгнэлтийн заалт нь Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2-т заасан заалттай "Үүрэг гүйцэтгэгч" гэдэг үг байхгүйгээр холбогдолгүй болно гэж байхгүй.

Хууль зүйн үр дагаврын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж ч хүчингүй болох ёстой.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцсон УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Бат-Үүл, С.Батчулуун нар тайлбарлахдаа: "Улсын Их Хурлын тайлбарыг Үндсэн хуулийн Цэцэд урьд нь бид гаргаж өгсөн ба өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайдын нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчийг томилсон тухай 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 10 тоот дүгнэлтийг Үндсэн хуулийн дээрх заалттай холбогдолгүй байна гэсэн үндэслэлээр хүлээн авах боломжгүй гэж байгаагаа дахин илэрхийлье гэв.

ХЯНАВАЛ:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 10 тоот дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж Улсын Их Хурлаас 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр гаргасан 12 дугаар тогтоолын хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн болох нь Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны явцад болон бусад нотлох баримтаар батлагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль ёсоор нэр дэвшүүлж санал болгоогүй байхад Ж.Наранцацралтыг нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн Цэцийн 10 тоот дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр сарын 31-ний 12 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

| | |
|---|---|
| **Дарга** | **Г.СОВД** |
| **Гишүүд** | **Л.БААСАН** |
| | **Н.ЖАНЦАН** |
| | **С.ЖАНЦАН** |
| | **Д.ЧИЛХААЖАВ** |
| | **Ж.БЯМБАЖАВ** |
| | **Ж.БЯМБАА** |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот |

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Ж.Бямбаа даргалж, гишүүдэд Л.Баасан /илтгэгч/, Н.Жанцан, Д.Чилхаажав, Ж.Бямбажав, нарийн бичгийн даргад Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Ж.Бямбадорж, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Шаравжамцын Батбаяр, Хашбатын Хулан нар оролцов.

1. Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны иргэн Жамсрангийн Бямбадорж Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөл, уг өргөдлийг тодотгон бичгээр гаргасан тайлбартаа: "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйл, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5-д заасан "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах ... тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй", мөн зүйлийн 4-т заасан "ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Хуульд заасан болзлыг хангаж тэтгэвэр авах эрх нэгэнт үүссэн бол тэтгэврээ тогтоолгон авах эрх хэрэгжих нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хөдөлмөр, төлсөн шимтгэлийн үр дүн нь тэтгэвэр тогтоолгон авах эрх юм. Түүнийг ямар нэгэн үндэслэлээр өөрөө хүсээгүй тохиолдолд зогсоож болохгүй, нөгөө талаар өөрийн амьдрал ахуйд нэмэр болох, амьжиргаагаа өөд татахын тулд хэрдээ таарсан ажил хийхэд түүний тэтгэвэр авч байгаа нь саад болохгүй. Хөдөлмөрийн гэрээг хоёр талын сайн дурын үндсэн дээр байгуулдаг. Цалин хөлс нь нийгмийн даатгалын санд огт хамаагүй юм.

Хуульд заасан үндэслэлээр тэтгэврээ тогтоолгон авч байгаа хүмүүсээс ажил албан тушаал эрхлээгүй хэсэг нь тэтгэврээ авч байхад албан хаагч, эсхүл хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад урьд тогтоолгосон тэтгэврээ зогсоолгох нь иргэдийг ажил, албан тушаалаар нь ялгаварлаж буй явдал мөн. Өндөр насны тэтгэвэр нь төрөөс иргэнд үзүүлж буй хайр хишиг биш. Иргэн хүн өндөр насалсан үедээ амьдрала хүрэлцэхүйц тэтгэвэр авна гэж тодорхой эрсдэлтэйгээр даатгуулж, зохих шимтгэл төлж байгаа болно. Энэ бол нэг ёсны даатгалын байгууллагатай байгуулсан гэрээ, болзол, журмынхаа дагуу тэтгэврээ авч байгаа явдал мөн. Хуулиар хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад, төрийн алба хаашигчдын тэтгэврийг зогсоож байгаа нь тэр хүний тэтгэврийн мөнгийг нийгмийн даатгалын санд ашиг болгон үлдээж, уг иргэнд орох ёстой байсан мөнгөн орлогыг дайчлан авч байгаа явдал билээ. Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуульд буй "... хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн

зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө" гэсэн заалтыг зөрчжээ. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц асуудалд бодитой хандаж, маргааныг шийдвэрлэнэ гэдэгт итгэж байна гэжээ.

2. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны иргэн Д.Төмөртогоо Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тэтгэвэр тогтоолгосод хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол тэтгэврийг нь зогсоох заалт орсон нь агуулгаараа өндөр настнуудыг ажлаа хий гэсэн агуулгатай болж Монгол Улсын Үндсэн хуульд буй "хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Энэ хуулийн зохицуулалт нь тэтгэвэр авах, хөдөлмөрлөх хоёрын аль нэгийг сонго гэсэн утгыг илэрхийлснээрээ "иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, ... амрах эрхтэй" гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна. Мөн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд буй "хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" гэсэн заалт зөрчигдөж байна.

Зах зээлийн харилцааны өнөө үед хэн чадвартай нь хөдөлмөрлөж байж амьдрах эрхтэй. Нэгэнт хөдөлмөрлөж байгаа бол хаана ажиллаж байгаагаас үл хамааран Үндсэн хуульд заасан эд мөнгөний тусламж авах эрхийг эдлэх ёстой.

Улсын Их Хурал, Засгийн газар ард түмний томоохон хэсэг болж буй ахмад настнуудыг тэтгэвэр тэтгэмжийн хувьд ялгаварлах байдлаар хандах, хэсэг бүлэг хүмүүсийг ажилгүй болгож, хүний эрхэнд халдаж буй ноцтой асуудалд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга, гишүүд та бүхнийг нухацтай хандаж ... ихээхэн нөлөө бүхий шийдвэр гаргана гэдэгт итгэж байна гэжээ.

Иргэн Д.Төмөртогоо өөрийн өргөдлийг тодотгосон тайлбарыг бичгээр ирүүлсэн байна.

3. Улсын Их Хурлын даргын 1997 оны 3 дугаар сарын 29-ны 50 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Шаравжамцын Батбаяр Үндсэн хуулийн Цэцэд бичгээр ирүүлсэн тайлбартаа: Иргэн Ж.Бямбадоржийн гомдлыг хүлээн авахгүй байх доорхи үндэслэлтэй байна. Үүнд:

1/Нийгмийн даатгалын багц хууль бүхэлдээ тус улсын иргэдийн тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Гомдолд дурьдсан заалтууд нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5-д заасан "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах ... тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэсэн заалтыг баталгаажуулан хуульчилжээ.

2/Дээрхи хэм хэмжээ үйлчилснээр иргэдийн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хязгаарлагдахгүй. Үндсэн хуулийн 16 дугаар

зүйлийн 4,5-д заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалт нь энд заагдсан эрхүүдийг зэрэг эдлэх тухай ойлголт биш. Тухайн эрхүүдийг тус тусын хуулиар баталгаажуулан зохицуулдаг.

3/Иргэд санаачлан эсхүл тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан гэдэг үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай одоо мөрдөгдөж буй Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд заасан. Энэ бол иргэдийн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хуульчилж өгсөн заалт болно.

4/Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 3,4-т Монгол Улсын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан болзол нөхцөлийг хангасан иргэдийг Захиргаа санаачлан ажлаас чөлөөлөх тухай заажээ. Энэ бол нийгмийн даатгалын шинэ хуулиудад тусгагдсан тэтгэвэр тогтоох болзол гэсэн утгаар ойлгогдох болов уу.

5/Өргөдөлд дурьдсан иргэд өөрсдийн амьдрал ахуйд нэмэр болох, амьжиргаагаа өөд татахын тулд хэр тохирсон ажил хийхэд саад болохгүй гэдэг асуудал бол цаашид анхаарвал зохих зүйл бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийг шинэчлэхэд шийдвэрлэх боломж бий.

6/Цалин хөлс нь нийгмийн даатгалын санд огт хамаагүй гэж бичсэн нь харьцангуй ойлголт. Учир нь нийгмийн даатгалын сангийн багагүй хэсгийг Засгийн газар улсын төсвөөс бүрдүүлдэг болно гэжээ.

4. Гомдол гаргагч иргэн Ж.Бямбадорж Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Миний бие Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан хүсэлт бол тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа нийт хүмүүсийн эрх ашигтай холбоотой асуудал болно. Би албан ажлын шугамаар "Сутай" хэмээх жижиг үйлдвэрт очиж ажиллахад тэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон олон хүн ажиллаж байна. Тэд ажлын шаардлагыг бүрэн биелүүлдэг, хөдөлмөрийн чадвар сайтай хүмүүс атал өндөр насны тэтгэвэр тогтоолгосон гэдгээр одоо ажлаас халагдах, эсхүл нэгэнт тогтоолгосон тэтгэврээ зогсоох асуудалд тулаад байна.

Иргэд нийгмийн даатгалын санд шимтгэл төлж байгаа нь тэтгэвэр авах нөхцөлийг аяндаа бүрдүүлдэг байна. Энэхүү эрхийг Улсын Их Хурлаас 1997 оны 1 дүгээр сарын 16-нд гаргасан хуулиар зөрчсөн байна" гэв.

5. Улсын Их Хурлын даргын 1997 оны 53 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Хулангаас: Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг ямар цаг үед хэлэлцсэн гэдэг талаар тайлбарлая. Үүнийг манай улсад тэтгэврийн хууль тогтоомж хөгжиж ирсэн түүх, бусад орны тогтолцоотой холбон үзэх нь чухал. Манай улсад тэтгэвэр, тэтгэмжийн санг улс хариуцдаг системийг өөрчилж,

ажил олгогч, ажилтан өөрсдөө сан байгуулдаг шинэ системийг бий болгох зорилгоор нийгмийн даатгалын багц хуульд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн юм. Өөрөөр хэлбэл Герман улсад үүсч бий болсон эв нэгдлийн /солидарность/ тогтолцоог түс улсад нэвтрүүлэх зорилгыг нийгмийн даатгалын багц хуульд тусгах зорилт тавьсан. Өнөөдөр тэтгэвэр тогтоолгосон хүмүүс төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нь тэд хөдөлмөрөө шинээр үнэлж, хөдөлмөрийн чадвартай гэдгээ нотолж байх тул тэдний тэтгэврийг зогсоохоос өөр аргагүй. Учир нь тэтгэврийг Үндсэн хуульд заасны дагуу иргэд хөдөлмөрийн чадваргүй байгаа тохиолдолд олгодог гэв.

6. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Шаравжамцын Батбаяраас: Нийгмийн даатгалын багц хууль бол нийгмийн даатгалын тогтолцоог шинэ систем, журамд шилжүүлэхэд чиглэсэн. Иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос хойш төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөрлөх эрх нээлттэй байгаа. Ийм нөхцөлд тогтоогдсон тэтгэврийг зогсоохоос өөр арга байхгүй. Иргэн Д.Төмөртогоогийн өргөдлийн шаардлага бол Ж.Бямбадоржийн гомдолтой утга санаа нэг тул түүнд өгөх хариулт Ж.Бямбадоржид өгсөн хариулттай адилхан болно. Нөгөө талаар иргэн Д.Төмөртогоо зарим асуудлыг зөрүүлэн ойлгосон болохтой гэдгийг тодотгох нь чухал байна гэв.

ХЯНАВАЛ:

1. Иргэдийн тэтгэвэр авах эрх нь хуульд заасан болзол журмыг хангасны үндсэн дээр үүсдэг Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрх тул энэ эрхийн харилцааг нэгэнт үүссэний хойно хөдөлмөр эрхэлсэн гэх үндэслэлээр зогсоож болох хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Насны тэтгэвэр тогтоолгосноор иргэдийг хөдөлмөрлөх чадваргүй гэж үзэх үндэслэлгүйн зэрэгцээ иргэдийн тэтгэвэр авах болон ажил, албаа чөлөөтэйгээр сонгох зэрэг үндсэн хуульд заасан иргэдийн эрхүүдийн нэг нь хэрэгжсэнээр нөгөө нь зогсоох, эсвэл эдгээр эрхүүд тус тусдаа хэрэгжинэ гэсэн зохицуулалт үйлчилж болохооргүй байна.

Тэтгэвэр бүхий иргэд төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах үед хуульд заасан болзлоор зайлшгүй хэрэгжих тэтгэврийг зогсоох нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн тэтгэвэр авах болон хөдөлмөрлөх эрхийг хязгаарласан шинжтэй байна.

3. Монгол Улсын тэтгэврийн хуулиар насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дотор хөдөлмөрийн харилцааны субъект байж чадах хөдөлмөрлөх чадвар бүхий иргэд цөөнгүй байгаагаас гадна тэтгэвэр бүхий ихэнх хүмүүсийн амьжиргааны түвшин, тэтгэврийн хэмжээ нь тэтгэврээ авахын сацуу хөдөлмөрийн

гэрээгээр ажиллах, төрийн алба хаших, хувиараа аж ахуй эрхлэх зэргээр зайлшгүй хөдөлмөрлөхийн аяндаа шаардах болжээ.

Эдгээр байдлуудаас үндэслэн үзэхэд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны хуулийн 1 дүгээр зүйлд буй "тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын тэтгэврийг зогсоосугай" гэсэн заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн Даатгуулагчийн тэтгэвэр авах эрх хэрэгжих гэсэн 4 дүгээр зүйлд буй "Тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4,5-д буй "иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, өндөр наслах ... хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна. Энэ талаар иргэн Ж.Бямбадорж, Д.Төмөртогоо нарын гаргасан гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 3-т буй "Тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тэтгэврийг зогсоосугай" гэсэн заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 4-1 зүйлийн "тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4,5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| Дарга | Ж.БЯМБАА |
| Гишүүд | Л.БААСАН |
| | Н.ЖАНЦАН |
| | Д.ЧИЛХААЖАВ |
| | Ж.БЯМБАЖАВ |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

**Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хорооны 1997 оны 03 тоот тогтоол Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай**

| | | |
|---|---|---|
| 1997 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот |

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүн Н.Жанцан, С.Жанцан, Д.Чилхаажав, Ж.Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг оролцуулан хийв. Энэхүү дүгнэлтийг Төрийн ордны 251 тоот өрөөнд гаргав.

Цэцийн хуралдаанаар Сонгуулийн Ерөнхий Хорооны 1997 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 03 тоот тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд маргагч талуудыг төлөөлж Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүн Б.Долгор, Н.Батболд, өргөдөл гаргагч Ч.Доржгочоо, О.Дашням, гуравдагч этгээд П.Очирбатын төлөөлөгч Б.Дэлгэрмаа, С.Баярцогт, Б.Энэбиш нар оролцов.

Монгол Улсын иргэн Ч.Доржгочоо Цэцэд хандан гаргасан өргөдөлдөө: "П.Очирбат нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 1990-1993 онуудад сонгогдож ... бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгч болох нь тодорхой байхад ... Сонгуулийн Ерөнхий Хороо 1997 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 03 тоот тогтоол гаргаж, Пунсалмаагийн Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгосон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дугаар заалтыг зөрчсөн байна" гэжээ.

Иргэн О.Дашням өргөдөлдөө: "Одоогийн Ерөнхийлөгч П.Очирбатын нэрийг дахин нэр дэвшүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна" гэжээ.

Иргэн Ч.Доржгочоо бичгээр ирүүлсэн тайлбартаа: "П.Очирбат бол 1990 онд ... Ерөнхийлөгчөөр сонгогдож, ... тангараг өргөж Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ эдэлсэн билээ. ... хуулиудад бүх ард түмнээр сонгогдсоноос бүрэн эрх нь эхлэх тухай ямар ч заалт байхгүй. Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2-т ... Ерөнхийлөгчийг 4 жилийн хугацаагаар сонгоно. ... 7-д "Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно" гэж заасныг үзэхэд ... Ерөнхийлөгч нийтдээ 8 жил дараалан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх Үндсэн хуулийн агуулга байна. ...Одоо 03 дугаар тогтоолоор сонгогдвол 11 жил Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх болж байна" гэжээ.

Иргэн О.Дашням тайлбартаа: "БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль"-ийн ... 13 дугаар зүйлийн 4-т "Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно" гэсэн заалт байгаа нь одоо дагаж мөрдөж байгаа Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь заалттай ижил байна. ... П.Очирбат 1990.03.21-нд АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар, 1990.09.03, 1993.06.17-нд Ерөнхийлөгчөөр тус тус сонгогджээ.

П.Очирбат 1993 онд улиран сонгогдож байна гэдгээ хүлээн зөвшөөрч байжээ. Тухайлбал 1993 оны сонгуулийн мөрийн хөтөлбөртөө улиран сонгогдвол ... гэжээ. Ер нь Үндсэн хуульд /шинэ, хуучин хууль/ Ерөнхийлөгчийг сонгох журмын ялгааг харгалзан үзэж, 3 дахь удаагаа сонгож болно гэсэн ямар нэг хоёрдмол санаа үгүй байна" гэжээ.

Сонгуулийн Ерөнхий Хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгор, Н.Батболд нар тайлбар гаргахдаа: "П.Очирбат нь 1990 онд БНМАУ-ын АИХ-аас, 1993 онд шинэ Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлд заасан зарчим, журмаар ... сонгогдож ... БНМАУ-ын болон Монгол Улсын Ерөнхийлөгч болсон билээ.

Үндсэн хуулийн гучиннэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан ... заалт нь АИХ-аас сонгогдсон БНМАУ-ын ... Ерөнхийлөгчид хамаарахгүй гэсэн дүгнэлтийг иш үндэс болгон Сонгуулийн Ерөнхий Хороо шийдвэрээ гаргасан болно" гэжээ.

Нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбатын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дэлгэрмаа, С.Баярцогт, Б.Энэбиш нар "Монгол Улсын Үндсэн хууль 1992 оны 2 дугаар сарын 13-наас дагаж мөрдөгдсөн учир шинэ Үндсэн хуулиар зохицуулсан харилцаа мөн 13-наас эхлэн тоолно. ... БНМАУ-ын Үндсэн хуулийн шилжилтийн тухай хуулиар батлагдан бүрдүүлсэн ... төрийн дээд байгууллагуудыг тус

түүний шинэ сонгууль хүртэл ажиллуулахаар хүлээн зөвшөөрсөн юм. ... өмнөх төрд Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан хүн дахин сонгогдож болохгүй ... гэж байхгүй" гэжээ.

Ерөнхийлөгчид нэр дэвшигч П.Очирбатын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Баярцогт, Б.Дэлгэрмаа нар Цэцийн хуралдаанд оролцож өгсөн тайлбартаа: "БНМАУ-ын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхийлөгч хоёр сонгогдох, эрх хэмжээний хувьд ялгаатай. Ерөнхийлөгчийн тухай хуулийн тодорхойлолтоос харагдаж байна. Тухайлбал БНМАУ-ын Ерөнхийлөгчийг АИХ-аас сонгосон, Одоогийн Ерөнхийлөгч бол шинэ Үндсэн хуулийн дагуу анх удаа сонгогдсон гэж үзэж байна.

Иймд П.Очирбат хоёр дахь удаагаа нэр дэвшиж байгаа юм. Ерөнхийлөгчийн ярьж хэлж байсныг хуулийн заалттай хутгаж болохгүй. Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалт эргэж үйлчлэх хүчингүй юм" гэжээ.

Нэхэмжлэгч иргэн Дашням, Доржгочоо нар Цэцийн хуралдаанд оролцож өгсөн тайлбартаа "1990, 1993 онд сонгогдсон Ерөнхийлөгч эрх мэдлийн хувьд зарчмын ялгаагүй. П.Очирбат хоёр удаа Ерөнхийлөгчөөр сонгогдсон, тухайлбал хоёр удаа тангараг өргөсөн, Үндсэн хуульд заасан бүрэн эрхийг 1993 оны 6 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн. Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар зөвхөн нэг удаа улиран сонгогдож болно" гэж хоёрдмол утгагүй заасан.

Иймд П.Очирбатыг Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгох тухай Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэр Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна. Үндсэн хуулийн Цэц шударга шийдвэр гаргана гэдэгт итгэж байна" гэв.

Сонгуулийн Ерөнхий Хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгор, Н.Батболд нар Цэцийн хуралдаанд оролцож өгсөн тайлбартаа: "Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалт нь АИХ-аас сонгогдсон БНМАУ-ын Ерөнхийлөгч болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг 1992 оны 2 дугаар сарын 12-ноос 1993 оны 6 дугаар сарын 18 хүртэл хэрэгжүүлж байсан БНМАУ-ын Ерөнхийлөгчид хамаарахгүй гэдэг үндэслэлийг иш үндэс болгож, Сонгуулийн Ерөнхий Хороо шийдвэрлэн гаргасан юм. Энэ шийдвэр Үндсэн хууль зөрчөөгүй" гэжээ.

ХЯНАВАЛ:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1990 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд заасан БНМАУ-ын Ерөнхийлөгч, Монгол Улсын шинэ Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгч нь хэрэгжүүлэх бүрэн эрх болон сонгогдох зарчмынхаа хувьд хоорондоо эрс ялгаатай байна.

2. Нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбат нь нийт ард түмнээс Ерөнхийлөгчөөр сонгогдохоор хоёр дахь удаагаа нэр дэвшиж байна.

3. Сонгуулийн Ерөнхий Хорооноос нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбатыг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлснийг бүртгэж авсан 1997 оны 3 дугаар сарын 27-ны 03 тоот тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хорооны 1997 оны 3 дугаар сарын 27-ны 03 тоот тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу мэдэгдэхийг УИХ-д уламжилъя.

| | |
|---|---|
| Дарга | Г.СОВД |
| Гишүүд | Н.ЖАНЦАН |
| | С.ЖАНЦАН |
| | Д.ЧИЛХААЖАВ |
| | Ж.БЯМБАЖАВ |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 6 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот |

**Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 тоот тогтоолын 1 дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг явуулсан байдал нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар**

Үндсэн хуулийн Цэцийн энэ дүгнэлтийг 1997 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 14цагт Төрийн ордны 251 дүгээр өрөөнд үйлдэв.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн Цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүдээс Л.Баасан, Н.Жанцан, Д.Чилхаажав /илтгэгч/, Ж.Бямбажав нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд маргагч талыг төлөөлж иргэн С.Зориг, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг, УИХ-ын Тамгын газрын орлогч дарга Б.Энэбиш, гэрчээр УИХ-ын гишүүн До.Ганболд, М.Чимэдцэрэн нар оролцов.

Иргэн С.Зориг 1997 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Үндсэн хуулийн Цэцэд хандан гаргасан өргөдөлдөө: "Импортын барааны гаалийн татварын тухай 1997 оны 04 дүгээр сарын 18-ны Монгол Улсын Их Хурлын 24 тоот тогтоолын нэг дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48 минутад явуулсан байдал нь Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол УИХ-ын нийт гишүүдийн дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийднэ" гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48 минутад явуулсан санал хураалтад оролцсон гишүүдийн нэрсийн жагсаалтыг цахим тооцоолуураас авч үзэхэд АНУ-д томилолтоор явж байсан гишүүн Д.Дашпүрэв санал хураалтад оролцсоноор гарчээ. Үндсэн хууль зөрчиж гаргасан тогтоолыг хүчингүй болгож, шинээр хэлэлцүүлэг явуулан батлуулах, цаашдаа УИХ-ын хуралдааныг зөвхөн хуулийн хүрээнд явуулж байх нь хуулийг дээдлэх ажлыг төр өөрөөсөө эхэлж, нийт иргэдээ үлгэр дууриал болох юм" гэжээ.

УИХ-ын гишүүн Д.Дашпүрэв, Р.Одонбаатар нар Үндсэн хуулийн Цэцэд бичгээр тодорхойлолт ирүүлж, 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанд оролцоогүй болохоо батлан илэрхийлэв.

УИХ-ын гишүүн До.Ганболд, М.Чимидцэрэн, Д.Батнасан, Ц.Төмөртогоо нар 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн үдээс хойшхи хуралдаанд биечлэн оролцож, импортын барааны гаалийн татварыг тэг байлгах нь зүйтэй гэсэн томъёоллоор хураасан санал хураалтад оролцсон болохоо илэрхийлэв. Тэдний зарим нь /До.Ганболд, М.Чимидцэрэн, Д.Батнасан/ Үндсэн хуулийн Цэцэд хандан энэ талаар бичгээр тодорхойлолт ирүүлжээ. Үүнд:

УИХ-ын гишүүн М.Чимидцэрэн Үндсэн хуулийн Цэцэд бичгээр ирүүлсэн тодорхойлолтондоо: "Миний бие тухайн хуралдаанд оролцож байсны хувьд хуралдаан 51 хүний ирцтэй байсныг тоолсон билээ. Эзгүй байсан гишүүний товчлуур дарагдсан тухайд бол Д.Дашпүрэв гишүүний товчлуурыг миний бие санамсаргүйгээр дарсан бөгөөд ингэхдээ өөрийн товчлуурыг дараагүй болно. Иймээс тус чуулганы хуралдааныг хуулийн дагуу явагдсан гэж үзэж байгаа бөгөөд шаардлагатай бол энэ тухай гэрчлэхэд бэлэн байгаагаа мэдэгдье" гэжээ.

УИХ-ын гишүүн До.Ганболд Үндсэн хуулийн Цэцэд бичгээр ирүүлсэн тодорхойлолтондоо: "... УИХ-ын чуулганы энэ оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд миний бие оролцсон нь үнэн бөгөөд харин цахим тооцоолуурын ирц дээр хуралдаанд оролцоогүйгээр тэмдэглэсэн байна. Өнгөрсөн хугацаанд Татварын багц хуулийн төслийн Төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хорооны ажлын хэсгийн ахлагчаар томилогдон ажилласан бөгөөд албан үүргийнхээ дагуу уг асуудлыг хэлэлцэж байх үед хуралдаанд оролцохгүй байх эрх надад байхгүйг болгооно биз ээ. Цахим тоолуур, Тамгын газрын ажилтан хоёрын бүртгэсэн ирц зөрж байгаа нь техникийн алдаанаас болсон нь тодорхой. Иймээс импортын бараанд ноогдуулах хураамжийг тэглэх УИХ-ын тогтоолыг эцэслэн батлах үед УИХ-ын чуулганы ирц байвал зохих хэмжээндээ хүрээгүй мэтээр өргөдөл өгсөн нь үнэнд огт нийцэхгүй болно" гэжээ.

УИХ-ын гишүүн До.Ганболд 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн УИХ-ын чуулганы хуралдаан дээр уг тогтоолын төслийн талаарх Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хорооны дүгнэлтийг 16 цаг 11 минутын орчимд уншиж танилцуулжээ.

УИХ-ын чуулганы 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны протоколоос үзвэл Импортын барааны гаалийн татвар тэг байх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураахад 27 гишүүн зөвшөөрч, 24 гишүүн татгалзаж, бүгд 51 гишүүн оролцон, 52,9 хувийн саналаар уг асуудал дэмжигджээ. Энэ тогтоолын төслийн эхний хэлэлцүүлгийг дуусгаж, хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгэе гэсэн томъёоллоор санал хураахад 34 гишүүн зөвшөөрч 19 гишүүн татгалзаж, 64,2 хувийн саналаар батлагдан 16 цаг 50 минутад уг асуудлыг хэлэлцэж дуусчээ.

Чуулганы энэ өдрийн хуралдааны протокол болон Тамгын газрын ажилтнуудын ирцийн бүртгэлээс харвал Д.Дашпүрэв нарын 18 гишүүн чөлөөтэй, Р.Одонбаатар нарын 5 гишүүн өвчтэй гэж бүртгэгджээ. 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48, 16 цаг 50 минутад явагдсан 2 санал хураалтын жагсаалтыг цахим тооцоолуураас авч харахад Р.Одонбаатар, Д.Дашпүрэв нар санал хураалтад оролцон зөвшөөрсөн санал өгсөн, М.Чимидцэрэн, До.Ганболд, Ц.Төмөртогоо, Д.Батнасан нарын гишүүд санал хураалтад оролцоогүй гэж гарсан байв.

УИХ-ын гишүүн М.Чимидцэрэн Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр тайлбарлахдаа: "Би ярын эгнээний 3 дахь суудалд Дашпүрэв гишүүний суудал дээр суугаад Г.Ганхуяг гишүүнтэй ярьж сууж байгаад санал хураалт явуулах үед Дашпүрэв гишүүний товчлуурыг дарсан, өөрийнхийгөө дараагүй. Энэ санал хураалт нэрээр хураасан санал хураалт биш байсан" гэв.

УИХ-ын гишүүн До.Ганболд Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр тайлбарлахдаа: "Би татварын хуулийн ажлын хэсгийн ахлагч байсан учир хууль хэлэлцэж, санал хураах байхад ороогүй байх нөхцөл байхгүй. Би энэ санал хураалтад оролцож байсан. Ирц хүрэхгүй бол Ринчин хурал даргалагчид мэдэгдэх ёстой" гэв.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Сайханбилэг Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр тайлбарлахдаа:

1. Тэр өдрийн хуралдаан хуульд заасан ирцтэй явагдсан. Өвчтэй, чөлөөтэй 23 гишүүн байж, 53 гишүүн оролцсон.

2. До.Ганболд нарын 4 гишүүн хуралд байж санал хураалтад оролцон саналаа өгсөнөө нотолцгоож байна.

3. Хоёрхон минутын дараа явагдсан санал хураалтанд 53 гишүүн оролцсон.

4. Санал хураалт явуулдаг компьютерийн системийн согоггүйг нотолсон нотлох баримтыг Цэцийн хуралдаанд өгсөн.

5. 76 компьютерийн гар бүгд масстай учир скочоор боосон байдаг бөгөөд хажуугаар нь чангахан гишгээд өнгөрөхөд л зарим гар нь ажиллаж эхэлдэг тухай техникийн ажилчид баталж байгаа.

6. Хажуу талынхаа гишүүдийн кнопыг дарах явдал хаана байдаг.

7. 51 гишүүн хүрээгүй тохиолдолд дэг сахиулагч хуралдаан даргалагчид заавал мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухайн үед ингээгүй нь ирц бүрэн байсныг нотолж байна" гэв.

УИХ-ын гишүүн, иргэн С.Зориг Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр тайлбарлахдаа: "Цахим тооцоолуур үнэн ажилладаг гэж үзэж байсан учраас одоо болтол компьютерийн системийг солиогүй гэж үзэж байгаа юм. Энэ гурван гишүүний хувьд техникийн буруу биш, хариуцлагын асуудал гэж үзэж байна. Хуралдааны ирц бүрэн эсэхийг Их Хурал даргалагч бүрэн хянаж байх ёстой. Тухайн өдрийн 15 цаг 30 минутад дээрх 4 гишүүн байсныг Ринчингийн бүртгэл нотолж байгаа бол 16 цаг 48 минутад дээрх 4 гишүүн байхгүй байсныг компьютерээс авсан жагсаалт нотолж байна. Энэ гишүүд байсан гэж би итгэж чадахгүй. Их Хурлын бүх санал хураалт шийдвэрлэх санал хураалт байна. Компьютер алддаг гэж үзвэл Их Хурлын баталсан бүх хууль хүчингүй буюу Үндсэн хууль зөрчиж гарсан гэж үзэх үндэстэн" гэжээ.

ХЯНАВАЛ:

1. Импортын барааны албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 16 цаг 48 минутад хэлэлцүүлэх үед гадаад улсад томилолтоор ажилласан, өвчтэй байсан гишүүдийг хуралд оролцож санал өгснөөр тооцон бүрэн бус бүрэлдэхүүнтэйгээр санал хураалгасан, мөн өдрийн 16 цаг 50 минутад гишүүн Р.Одонбаатар, Д.Дашпүрэв нарыг

хуралд хүрэлцэн ирснээр дахин санал хураалгасан зэрэг нь Улсын Их Хурал хуралдааныхаа явцад Монгол Улсын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь заалтыг зөрчсөн болох нь тогтоогдов.

Хуралд оролцоогүй гишүүдийн өмнөөс санал хураалтын товчлуурыг дарсан нь Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх, халдашгүй байдалд харшилж Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Иргэн С.Зоригийн энэ талаархи гомдлыг хүлээн авах нь зүйтэй байна.

2. Улсын Их Хурал импортын барааны албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх явцдаа хуралдааны журам, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зөрчиж байсан боловч энэ талаархи эцсийн шийдвэр гаргахад хуралдааны ирц бүрэн байсан тул импортын барааны гаалийн албан татварын тухай Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32,33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 11-ний оройн 16 цаг 48 минутын хуралдааны санал хураалтын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6, 29 дүгээр зүйлийн 2 дугаар зүйлүүдийг тус тус зөрчжээ.

2. Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуульд заасны дагуу 15 хоногийн дотор хянан хэлэлцэж, хариуг манайд ирүүлэхийг уламжилсугай.

**Дарга** — **Г.СОВД**

**Гишүүд** — **Л.БААСАН**
**Н.ЖАНЦАН**
**Д.ЧИЛХААЖАВ**
**Ж.БЯМБАЖАВ**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Л.Баасан даргалж гишүүн Н.Жанцан, Ж.Бямбаа, С.Жанцан, Ж.Бямбажав /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Энэхүү дүгнэлтийг Төрийн ордны 251 тоот өрөөнд үйлдэв.

Хуралдаанд өргөдөл гаргагч Г.Пүрэвжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч гишүүн Шаравжамцын Батбаяр, Тамгын газрын хуулийн зөвлөх Б.Өнөбаатар нар оролцов.

Иргэн Г.Пүрэвжав Үндсэн хуулийн Цэцэд хандан гаргасан өргөдөлдөө: "Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дүгээр заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дугаар заалтыг зөрчиж байна. Үүнээс болж аж ахуйн нэгж байгууллага нь тэтгэвэртэй буюу тахир дутуу хүнийг зохих тэнцэх ажил байсан ч ажилд авдаггүй, ажилд авсан нэг нь дуртай цагтаа Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дүгээр заалтаар ажлаас халдаг боллоо. ... Иймд хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дүгээр заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дугаар заалттай нийцэж байгаа эсэхийг ... нягтлан шалгаж, хянан шийдвэрлэж өгнө үү?" гэжээ.

Г.Пүрэвжав нь Үндсэн хуулийн Цэцэд бичгээр өгсөн тайлбартаа: "Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дүгээр заалт Үндсэн хууль зөрчиж байна хэмээн үзсэн юм. ... Үндсэн хуулиар олгогдсон "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн чадвар алдах, хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй гэж боддог. Гэтэл энэ эрх маань яагаад эрхэлж чадаж байгаа ажил, хөдөлмөрөө эрхлэх боломжгүй болгож байгаа юм бэ? ... Амьдрал дээр тэтгэврээ аваад ажил хийгээд байгаа хүн олон байгаа юм. Энэ хоёр эрхийг зөрчилдүүлэн хууль гаргаснаас намайг ажлаас халахад хүргэлээ гэжээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ша.Батбаяр тайлбар гаргахдаа: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар

зүйлийн 4, 5 дахь заалтууд иргэдийн ерөнхий эрхийг хуульчилж заасан агуулгатай. Тиймээс энэ заалтыг хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн заалтуудтай шууд тулган харьцуулж болохгүй юм.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах тухай хуулийн заалтын үндсэн зарчим нь тэтгэвэр авах болзол хангасан иргэн хүсэлтээ гаргах нь үндсэн ажлаа цаашид үргэлжлүүлэн хийх боломжгүй боллоо гэдгээ илэрхийлж, цалингийнхаа оронд тэтгэврээ авъя гэсэн утгыг агуулсан юм. Энэ нь тухайн иргэний ажил хөдөлмөр эрхлэх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг огт хязгаарлаагүй. Өөрөө хүсэлт тавьж, ажлаас гарсан, өөр ямар ч ажил, мэргэжил эрхлэх эрх нь нээлттэй байгаа. Гагцхүү уг ажил мэргэжилдээ тэнцэх эсэх, тухайн байгууллага хөдөлмөрийн гэрээ байгуулах эсэх нь Үндсэн хууль болон өөр хуулиар ч түлгаж болохгүй асуудал юм" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Батбаяр Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: "Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4-ийг зөрчөөгүй гэж үзэж байна. Харин Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-ийг өөрчилж, хүчингүй болгоогүй нь үнэн" гэв.

ХЯНАВАЛ:

1. 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдсөн Монгол Улсын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт хүчингүй болсон боловч уг заалт Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т хүчинтэй хэвээр байна.

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон гаргах ДҮГНЭЛТ:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Дарга** **Г.СОВД**
**Гишүүд** **Н.ЖАНЦАН**
**С.ЖАНЦАН**
**Ж.БЯМБАА**
**Ж.БЯМБАЖАВ**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай**

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 1997 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 13.00 цагт Төрийн ордны 251 тоот өрөөнд үйлдэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Ж.Бямбажав даргалж, гишүүн Л.Баасан /илтгэгч/, С.Жанцан, Ж.Бямбаа, Д.Чилхаажав нарын бүрэлдэхүүнтэй, Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Ё.Найгал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Алтангэрэл нар оролцов.

Нэг. Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэн Эрдэнэзуу музейн захирал Ёндонгийн Найгал Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: "Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгэр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэтрүүлэн гарчээ.

Төрийн өмчийн тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлд заасан нийтийн зориулалттай өмчид Хархорин суманд буй Эрдэнэзуу музей багтдаг ба энэхүү өмчийг ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал эдэлдэг байна. Гэтэл Эрдэнэзуу музейг шашны байгууллагын өмчид шилжүүлэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шийдвэрлэжээ.

Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 3-т төрийн өмчид байгаа түүх соёлын дурсгалт зүйлийг язгуур зориулалтаар ашиглахыг хоригложээ. Энэхүү заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг зөрчсөн байна. Эдгээр байдлуудыг хянан үзэхийг хүсье. Монгол Улсад Ерөнхийлөгчөөсөө эхлээд бид бүхэн Үндсэн хуулиа хүндэтгэх ёстой" гэжээ.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Моломын Алтангэрэл бичгээр ирүүлсэн тайлбартаа: "Монгол Улсын Ерөнхийлөгч 1997 онд 71 дүгээр зарлиг гарган Хархорин дахь Эрдэнэзуу музейг шашны нийтийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг чиглэл болгон шийдвэрлэсэн нь:

1. Эрдэнэзуу хийдийн тэргүүн хамба Намхайжамц нарын хүмүүс гарын үсэг зурсан хүсэлт, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Батмөнх, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга С.Батчулуун, Гандантэгчилэн хийдийн хамба лам Чойжамц, Монгол сүсэгтний холбоо, Монголын шашинтны ардчилсан нам зэрэг төрийн ба төрийн бус байгууллага, албан тушаалтны хүсэлт, санал хүсэлт,

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4-т буй "Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно" гэсэн заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн "ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүйн байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна" гэсэн заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-ийн 3-т "Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэнд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрхтэй. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно" гэсэн заалт, Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т буй "... Эртний хэрэм, цайз, ... сүм дуган, хийд ... байшин барилга зэрэг уран барилгын дурсгалыг ... түүх соёлын дурсгалт зүйлд хамааруулах" тухай заалт;

Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 4-т буй сүм хийд, шашин номын ажиллагаа эрхлэн явуулахад нь шаардлагатай музей, номын сан дахь түүх соёлын дурсгалт зүйлийг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасны дагуу хэрэглэх асуудлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ" гэсэн заалт;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4-ийн 2-т буй "... түүх соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал төрийн нийтийн зориулалттай өмчид хамаарна" гэсэн заалт. Мөн зүйлийн 4-т буй "төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлийг хуульд заасан нөхцөл журмын дагуу иргэн, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно", мөн хуулийн 27 дугаар зүйлийн 1-д буй "төрийн өмчийн эд хөрөнгийг ... хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно"; мөн хуулийн 30 дугаар зүйлийн 2-т буй "төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамаарснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр ... шилжүүлж болно" гэсэн заалтуудыг тус тус үндэслэсэн болно.

Хууль тогтоомжийн эдгээр заалтуудыг үндэслэл болгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан зарлигаар Эрдэнэзуу музейг "орон барилга" бусад холбогдох сан хөмрөгийнх нь хамт шашны нийтийн өмчид шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид

нийцүүлэн шийдвэрлэхийг Засгийн газарт чиглэл болгосон учир Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Харин Засгийн газар энэ чиглэлийг хүлээн аваад хууль зүйн дагуу хэрэхэн шийдвэрлэх нь түүний бүрэн эрхийн асуудал билээ" гэжээ.

Гурав. Гомдол гаргагч иргэн Ё.Найгал Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа "Эрдэнэзуу музей бол цогцолбороороо түүх соёлын дурсгалт зүйлд багтах төрийн нийтийн зориулалттай өмч болно. Энэхүү өмчийг захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал эдэлдэг. Гэтэл энэ эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч эдэлсэн тул түүнийг Үндсэн хуулийг зөрчиж эрхээ хэрэгжүүлсэн гэж гомдол гаргасан. Үүнээ дэмжих болно" гэв.

Дөрөв. Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Алтангэрэлээс: "Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын хуульд зааж олгогдсон эрх хэмжээнийхээ дагуу Засгийн газарт чиглэл өгч зарлиг гаргасан. Энэхүү зарлиг гаргах үед Засгийн газар хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцсэн учир Ерөнхий сайд чиглэл өгсөн зарлигт гарын үсэг зурсан байна" гэв.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1997 оны 4 дүгээр сарын 30-нд зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай 71 дүгээр зарлиг гарган Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Эрдэнэзуу музейг шашны байгууллагын нийтийн өмчлөлд шилжүүлсэн нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд шууд хамаарагдаагүй, өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын эрх мэдлийн төрийн нийтийн өмчийн асуудлыг шийдвэрлэсэн;

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 3-т заасныар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх агуулгаас хальж зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах, төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах утгаар гарсан;

3. Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг Монгол Улсын Засгийн газар албан ёсоор хүлээн авч шийдвэрлээгүй байхад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг гарснаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 2, 33 дугаар зүйлийн 3 дахь заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т буй "ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна" гэсэн заалтыг төрийн өмчийн эд зүйлсийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбон үзэх үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан

хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийг зөрчсөн;

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авсанаас хойш хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Үндсэн хуулийн Цэцэд марган хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Дарга** **Ж.БЯМБАЖАВ**

**Гишүүд** **Л.БААСАН**
**Ж.БЯМБАА**
**С.ЖАНЦАН**
**Д.ЧИЛХААЖАВ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар сарын 30-ны өдөр №271 Улаанбаатар хот

**Ан агнуурын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай**

Ан агнуурын тухай Монгол Улсын хуулийн 15, 18, 28 дугаар зүйлийн зарим заалтыг зөв ойлгож нэг мөр хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Ан агнуурын тухай Монгол Улсын хууль (цаашид "хууль" гэх)-ийн 15, 18, 28 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1. Хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "ан агнах эрхийн үнэмлэх"-тэй хуулийн 16 дугаар зүйлд зааснаар иргэн өөрийн ам бүлийн хүнсний болон бусад хэрэгцээнд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны нэр, агнах, барих хугацаа газрыг заасан ан амьтан агнах, барих тухайн сум, дүүрэг баг, хорооны засаг даргаас авсан эрхийн бичиг; иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нэн ховор ан амьтныг судалгаа шинжилгээний, ховор ан амьтныг судалгаа шинжилгээ соёл урлагийн зориулалтаар болон тусгай төлбөртэйгээр агнах, барихын тулд Төрийн захиргааны төв байгууллагаас, харин элбэг ан амьтныг судалгаа, шинжилгээ, соёл урлаг, эрүүл мэндийн

зэрэг зориулалтаар агнах, барих эрхийг сум дүүргийн Засаг даргаас зохих журмын дагуу тус тус олгосон зөвшөөрлийн бичгийг адилтган үзнэ.

2. Эрхийн бичиг, зөвшөөрлийн бичиг нь уг ажлыг эрхлэх төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварын дагуу хийгдсэн байвал зохино.

3. Монголын анчдын нийгэмлэг болон ан амьтан агнах, зохистой ашиглах асуудал эрхэлж байгаа төрийн бус бусад байгууллагын гишүүний үнэмлэх нь зөвхөн тухайн байгууллагын гишүүн болохыг нотлох баримт бичиг тул тэдгээрийг эзэмшигчид нь бусад иргэнээс давуу эрх эдлэхгүй бөгөөд ан агнах, барих эрхийн бичиг, зөвшөөрлийн бичгийг хуульд заасан журмын дагуу бусад иргэдийн нэгэн адил авч ан амьтан агнах, барих үйл ажиллагаа явуулж болно.

4. Хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "сумын Засаг даргын шийдвэрийг үндэслэн ангийн мэргэжлийн байгууллагатай ан амьтныг агнах барих гэрээ байгуулна" гэдгийг иргэн, агнуурын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж нь сумын Засаг даргын шийдвэр гаргуулан, түүнд үндэслэн Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 30-р зүйлд заасан ан амьтан хамгаалах зохистой ашиглах асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн зориулалтаар элбэг ан амьтны арьс, үс, мах, бусад түүхий эд бэлтгэх, тэжээвэр болгож өсгөж үржүүлэх, ан амьтан агнах, барих үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.

5. Гэрээ нь уг ажлыг эрхэлдэг Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварын дагуу хийгдсэн байна.

6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ийнхүү ан амьтан агнах эрхийн бичиг, зөвшөөрлийн бичиг олгохдоо хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ан амьтан агнах, барих арга барил, дадлага эзэмшсэн, холбогдох хууль тогтоомжийг судалсан, ангийн буу эзэмших эрхийн үнэмлэх авсан байдлыг үндэслэх бөгөөд хуульд заагаагүй бусад шаардлага тавихгүй.

7. Хуулийн 28 дугаар зүйлийн "Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэн" гэдэгт албан тушаалын хувьд ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох, арга хэмжээ ноогдуулах эрх үүрэгтэйгээс бусад иргэнийг хамааруулан ойлгоно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** — **Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

**ШҮҮГЧ** — **А.ДОРЖГОТОВ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 152 | Улаанбаатар хот |

**Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**

Газрын төлбөрийн тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтын ёсоор, "Хот, тосгон, бусад суурины газрын зэрэглэл, тэдгээрийн нэг гектарын суурь үнэлгээ, жилийн төлбөрийн дээд, доод хязгаар"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор, "Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог бүрийн 1 гектарын суурь үнэлгээ, жилийн төлбөрийн доод хязгаар"-ыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн газрын харилцааны алба, албан тушаалтан, сум, дүүргийн газрын асуудал хариуцсан ажилтанд газрын төлбөрийн асуудлыг эрхлүүлэхээр тогтоосугай.

3. Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан газрын төлбөрөөс орох орлогын зохих хувийг төв, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд П.Цагаан, Байгаль орчны сайд Ц.Адъяасүрэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Хөдөө аж ахуйн газрын суурь үнэлгээний нэгээс дээш тойрогт дэвсгэр нутаг нь багтаж байгаа сумдыг аль их талбай хамарсан тойрогт нь оруулж тооцож байхаар тогтоосугай.

5. Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэг болон хоёр буюу түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг дамжсан газар эзэмшигч, ашиглагчийн газрын төлбөрийн орлогыг аймаг, нийслэлийн төсөвт, бусад орлогыг сум, дүүргийн төсөвт оруулж байхаар тогтоосугай.

6. Газрын төлбөр ногдуулах аргачилсан зааврыг энэ оны 7 дугаар сарын эхний хагаст багтаан батлан гаргаж мөрдүүлэхийг Байгаль орчны сайд Ц.Адъяасүрэнд даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улаанбаатар хотын газрын үнэлгээ, газар ашигласны төлбөр тогтоох тухай" БНМАУ-ын

Засгийн газрын 1991 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 136 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Байгаль орчны сайд** **Ц.АДЬЯАСҮРЭН**

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙРГИЙН ХУВААРЬ

| Газрын үнэлгээний тойргийн нэр | Тойргийн индекс | Тойрогт нутаг дэвсгэр нь бүхэлдээ буюу дийлэнх нь хамарч буй аймаг, сумын нэр |
|---|---|---|
| 1.Хангай Хэнтийн уулархаг | ХУ | **Хөвсгөл аймаг**<br>1. Алаг-эрдэнэ<br>2. Баянзүрх<br>3. Рэнчинлхүмбэ<br>4. Түнэл<br>5. Цагаан-үүр<br>6. Улаан-уул<br>7. Чандмань-өндөр<br>8. Эрдэнэбулган<br>9. Цагааннуур<br>10. Ханх<br>11. Арбулаг<br>12. Бүрэнтогтох<br>13. Их-уул<br>14. Рашаант<br>15. Тосонцэнгэл<br>16. Төмөрбулаг<br>17. Цагаан-уул<br>18. Цэцэрлэг<br>19. Тариалан<br>20. Мөрөн<br>21. Галт<br>22. Жаргалант<br>23. Шинэ-идэр |

| | | |
|---|---|---|
| | | **Булган аймаг**<br>1. Баян-агт<br>2. Бугат<br>3. Могод<br>4. Орхон<br>5. Сайхан<br>6. Хангал<br>7. Хишиг-өндөр<br>8. Сэлэнгэ<br>9. Хутаг-өндөр<br>10. Булган<br>11. Тэшиг<br>12. Бүрэгхангай<br>13. Гурванбулаг<br>14. Дашинчилэн<br>15. Баяннуур<br>16. Рашаант<br>**Увс аймаг**<br>1. Өндөрхангай<br>2. Хяргас<br>3. Цагаанхайрхан<br>4. Зүүнхангай<br>**Завхан аймаг**<br>1. Баянтэс<br>2. Баянхайрхан<br>3. Нөмрөг<br>4. Сонгино<br>5. Түдэвтэй<br>6. Тэлмэн<br>7. Цэцэн-уул<br>8. Тэс<br>9. Асгат<br>10. Булнай<br>11. Идэр<br>12. Их-уул<br>13. Алдархаан<br>14. Шилүүстэй<br>15. Яруу<br>16. Отгон<br>17. Улиастай<br>18. Цагаанхайрхан<br>19. Цагаанчулуут |

| | | |
|---|---|---|
| | | **Архангай аймаг**<br>1. Цэцэрлэг<br>2. Ихтамир<br>3. Өндөр-улаан<br>4. Эрдэнэмандал<br>5. Жаргалант<br>6. Хотонт<br>7. Хайрхан<br>8. Батцэнгэл<br>9. Эрдэнэбулган<br>10. Цэнхэр<br>11. Булган<br>12. Чулуут<br>13. Хангай<br>14. Тариат<br>15. Цахир<br>16. Хашаат<br>17. Өлзийт<br>18. Өгийнуур<br>19. Түвшрүүлэх<br>**Өвөрхангай аймаг**<br>1. Бүрд<br>2. Зүйл<br>3. Зүүнбаян-улаан<br>4. Хужирт<br>5. Хархорин<br>6. Бат-өлзий<br>7. Уянга<br>**Орхон аймаг**<br>1. Баян-өндөр<br>2. Жаргалант<br>**Сэлэнгэ аймаг**<br>1. Алтанбулаг<br>2. Баруунбүрэн<br>3. Зүүнбүрэн<br>4. Сант<br>5. Түшиг<br>6. Цагааннуур<br>7. Шаамар<br>8. Хушаат<br>9. Сүхбаатар<br>10. Жавхлант<br>11. Сайхан |

| | | |
|---|---|---|
| | | 12. Орхонтуул<br>13. Баянгол<br>14. Орхон<br>15. Мандал<br>16. Хүдэр<br>17. Ерөө<br>**Баянхонгор аймаг**<br>1. Эрдэнэцогт<br>2. Галуут<br>3. Заг<br>4. Хүрээмарал<br>5. Жаргалант<br>6. Гурванбулаг<br>7. Баянбулаг<br>**Дархан-уул аймаг**<br>1. Дархан<br>2. Хонгор<br>3. Орхон<br>4. Шарын гол<br>**Төв аймаг**<br>1. Заамар<br>2. Лүн<br>3. Өндөрширээт<br>4. Баянцогт<br>5. Жаргалант<br>6. Угтаал<br>7. Сүмбэр<br>8. Цээл<br>9. Баянхангай<br>10. Аргалант<br>11. Алтанбулаг<br>12. Баяндэлгэр<br>13. Бүрэн<br>14. Дэлгэрхаан<br>15. Сэргэлэн<br>16. Эрдэнэсант<br>17. Архуст<br>18. Мөнгөнморьт<br>19. Эрдэнэ<br>20. Батсүмбэр<br>21. Борнуур<br>22. Баянчандмань<br>23. Зуун мод |

| | | |
|---|---|---|
| | | **Улаанбаатар**<br>1. Нийслэл<br>2. Налайх<br>3. Багануур<br>**Дорнод аймаг**<br>1. Баяндун<br>2. Баян-уул<br>**Хэнтий аймаг**<br>1. Жаргалтхаан<br>2. Биндэр<br>3. Баян-адарга<br>4. Дадал<br>5. Норовлин<br>6. Гурванбаян<br>7. Батноров<br>8. Хэрлэн<br>9. Өлзийт<br>10. Өмнөдэлгэр<br>11. Цэнхэрмандал<br>12. Батширээт |
| 2. Алтайн уулархаг | АУ | **Баян-өлгий аймаг**<br>1. Цэнгэл<br>2. Сагсай<br>3. Буянт<br>4. Дэлүүн<br>5. Булган<br>6. Толбо<br>7. Алтай<br>8. Улаанхус<br>9. Ногооннуур<br>10. Алтанцөгц<br>11. Баяннуур<br>12. Бугат<br>13. Өлгий<br>**Увс аймаг**<br>1. Сагил<br>2. Бөхмөрөн<br>3. Түргэн<br>4. Ховд<br>**Ховд аймаг**<br>1. Цэцэг<br>2. Мөнххайрхан |

| | | |
|---|---|---|
| | | 3. Дуут<br>4. Мөст<br>**Говь-алтай аймаг**<br>1. Чандмань<br>2. Тонхил<br>3. Халиун<br>**Баянхонгор аймаг**<br>1. Баянлиг<br>2. Баянговь<br>3. Баянцагаан<br>**Өмнөговь аймаг**<br>1. Баяндалай<br>2. Баян-овоо<br>3. Булган<br>4. Манлай<br>5. Мандал-овоо<br>6. Сэврэй<br>7. Ханхонгор<br>8. Цогтцэций<br>9. Цогт-овоо<br>10. Даланзадгад<br>**Өвөрхангай аймаг**<br>1. Богд |
| 3. Говийн уулархаг талархаг нутаг | ГТ | **Увс аймаг**<br>1. Давст<br>2. Завхан<br>3. Зүүнговь<br>4. Малчин<br>5. Наранбулаг<br>6. Өлгий<br>7. Өмнөговь<br>8. Тариалан<br>9. Тэс<br>10. Хархираа<br>11. Баруунтуруун<br>12. Улаангом<br>**Завхан аймаг**<br>1. Дөрвөлжин<br>2. Завханмандал<br>3. Сантмаргац<br>4. Ургамал<br>5. Эрдэнэхайрхан |

| | | |
|---|---|---|
| | | **Ховд аймаг**<br>1. Дарви<br>2. Зэрэг<br>3. Чандмань<br>4. Ховд<br>5. Буянт<br>6. Дөргөн<br>7. Манхан<br>8. Мянгад<br>9. Эрдэнэбүрэн<br>10. Жаргалант<br>11. Алтай<br>12. Үенч<br>13. Булган<br>**Говь-алтай аймаг**<br>1. Баян-уул<br>2. Дарви<br>3. Жаргалан<br>4. Тогрог<br>5. Хөхморьт<br>6. Шарга<br>7. Бигэр<br>8. Дэлгэр<br>9. Тайшир<br>10. Есөнбулаг<br>11. Алтай<br>12. Эрдэнэ<br>13. Бугат<br>14. Цогт<br>15. Цээл<br>**Баянхонгор аймаг**<br>1. Бөмбөгөр<br>2. Баян-овоо<br>3. Өлзийт<br>4. Жинст<br>5. Богд<br>6. Баацагаан<br>7. Бууцагаан<br>8. Баянхонгор<br>9. Шинэжинст<br>10. Баян-өндөр<br>**Өвөрхангай аймаг**<br>1. Нарийнтээл |

| | | |
|---|---|---|
| | | 2. Баруунбаян-улаан<br>3. Хайрхандулаан<br>4. Гучин-ус<br>5. Тогрог<br>6. Баянгол<br>7. Сант<br>**Дундговь аймаг**<br>1. Сайхан-овоо<br>2. Дэлгэрхангай<br>3. Өндөршил<br>4. Гурвансайхан<br>5. Өлзийт<br>6. Хулд<br>7. Луус<br>8. Сайнцагаан<br>9. Мандалговь<br>**Сүхбаатар аймаг**<br>1. Баяндэлгэр<br>2. Онгон<br>3. Наран<br>**Өмнөговь аймаг**<br>1. Гурвантэс<br>2. Ноён<br>3. Ханбогд<br>4. Номгон<br>5. Хүрмэн<br>**Дорноговь аймаг**<br>1. Мандах<br>2. Улаанбадрах<br>3. Хатанбулаг<br>4. Хөвсгөл<br>5. Айраг<br>6. Замын-үүд<br>7. Сайншанд<br>8. Алтанширээ<br>9. Даланжаргалан<br>10. Дэлгэрэх<br>11. Иххэт<br>12. Өргөн<br>13. Сайхандулаан<br>14. Эрдэнэ<br>**Говьсүмбэр аймаг**<br>1. Сүмбэр |

| | | |
|---|---|---|
| | | 2. Шивээговь<br>3. Баянтал |
| 4. Тал нутаг | Т | **Дорнод**<br>1. Баянтумэн<br>2. Матад<br>3. Халхгол<br>4. Цагаан-овоо<br>5. Чойбалсан<br>6. Хэрлэн<br>7. Чулуунхороот<br>8. Булган<br>9. Гурванзагал<br>10. Дашбалбар<br>11. Хөлөнбуйр<br>12. Сэргэлэн<br>**Өвөрхангай аймаг**<br>1. Тарагт<br>2. Өлзийт<br>3. Баян-өндөр<br>4. Арвайхээр<br>**Төв аймаг**<br>1. Баян<br>2. Баян-өнжүүл<br>3. Баянцагаан<br>4. Баянжаргалан<br>**Дундговь аймаг**<br>1. Дэлгэрцогт<br>2. Дэрэн<br>3. Говь-угтаал<br>4. Цагаандэлгэр<br>5. Баянжаргалан<br>6. Эрдэнэдалай<br>7. Адаацаг<br>**Хэнтий аймаг**<br>1. Галшар<br>2. Баянхутаг<br>3. Баянмөнх<br>4. Дархан<br>5. Дэлгэрхаан<br>6. Баян-овоо<br>7. Мөрөн |

| | | |
|---|---|---|
| | | Сүхбаатар аймаг<br>1. Асгат<br>2. Халзан<br>3. Уулбаян<br>4. Сүхбаатар<br>5. Мөнххаан<br>6. Түвшинширээ<br>7. Түмэнцогт<br>8. Баруун-урт<br>9. Дарьганга<br>10. Эрдэнэцагаан |

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН ЗЭРЭГЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН НЭГ ГЕКТАРЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ, ЖИЛИЙН ТӨЛБӨРИЙН ДЭЭД, ДООД ХЯЗГААР

| Суурин газрын | | | | | Жилийн төлбөрийн хязгаар (мян.төг) | |
|---|---|---|---|---|---|---|
| Ангилал | Зэрэглэл | Хүн амын тоо (мян. хүн) | Нэр | Суурь үнэлгээ (сая. төг) | доод | дээд |
| | нийслэл | | Улаанбаатар | 440,0 | 440,0 | 4400,0 |
| | улсын зэрэглэлтэй хот | 50,0-500,0 хүртэлх | Дархан | 300,0 | 300,0 | 900,0 |
| | | | Эрдэнэт | 200,0 | 200,0 | 600,0 |
| | | | Чойбалсан | 120,0 | 120,0 | 360,0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хот | Аймгийн зэрэглэлтэй хот | 30,0-50,0 хүртэлх | Улиастай | 50,0 | 50,0 | 100,0 |
| | | | Өлгий | | | |
| | | | Мөрөн | | | |
| | | | Цэцэрлэг | | | |
| | | | Ховд | | | |
| | | | Улаангом | | | |
| | | | Сүхбаатар | | | |
| | | 15,0-30,0 хүртэлх | Баянхонгор | 40,0 | 40,0 | 80,0 |
| | | | Өндөрхаан | | | |
| | | | Зуунмод | | | |
| | | | Баруун-урт | | | |
| | | | Сайншанд Даланзадгад | | | |
| | | | Арвайхээр | | | |
| | | | Мандалговь | | | |
| | | | Алтай | | | |
| | | | Булган | | | |
| | | | Зүүнхараа | | | |
| | | | Тосонцэнгэл | | | |
| | | | Чойр | | | |
| Тосгон | томоохон суурин сумын төв | 0,5-15,0 хүртэлх | Сумдын төв | 8,0 | 8,0 | |
| бусад суурин | | 0,5 хүртэлх | Бусад суурин | 5,0 | 5,0 | |

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙРОГ БҮРИЙН НЭГ ГЕКТАРЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ, ЖИЛИЙН ТӨЛБӨРИЙН ДООД ХЯЗГААР

| Газрын үнэлгээний тойргийн индекс | Бэлчээр | | | | | Тариалан | | Хадлан | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 гектарын суурь үнэлгээ мян.төг | 1 хонин толгойд ногдох газрын | | 1 гектарын жилийн төлбөрийн доод хязгаар төг | 1 хонин толгойд ногдох жилийн төлбөрийн доод хязгаар төг | 1 гектарын | | Ангилал | 1 гектарын | |
| | | хэмжээ га | суурь үнэлгээ мян.төг | | | суурь үнэлгээ мян.төг | жилийн төлбөрийн доод хязгаар төг | | суурь үнэлгээ мян.төг | жилийн төлбөрийн доод хязгаар төг |
| ХУ | 548,2 | 1,4 | 767,5 | 55 | 77 | 3859,0 | 386 | уулын нугын | 2478,3 | 248 |
| АУ | 202,9 | 2,3 | 466,7 | 20 | 47 | 2253,0 | 225 | уулын хээрийн | 2027,6 | 203 |
| ГТ | 208,6 | 2,2 | 458,9 | 21 | 46 | 1738,0 | 174 | тал хөндийн | 912,2 | 91 |
| Т | 381,7 | 1,5 | 572,6 | 38 | 57 | 3843,4 | 384 | голын хөндийн | 2090,9 | 209 |
| | | | | | | | | нам хотосын нугат | 2675,3 | 267 |

Тайлбар: 1 хонин толгойд болон 1 гектарт ногдох газрын төлбөрийг давхардуулан авахгүй.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 153 | Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 5, 64 дүгээр зүйлийн 4, 66 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг 1 дүгээр хавсралтын ёсоор, Гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Гаалийн улсын байцаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийнх нь 10 хувиар тогтоож олгосугай.

3. Улсын хил дээр ажиллаж буй гаалийн газар, хороо, алба, салбарын гаалийн ажилтнуудад албан тушаалын сарын цалингийнх нь 25 хувиар бодож хилийн нэмэгдэл олгож байсугай.

4. Гаалийн удирдах төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооны ажилтнуудын түр буюу улирлын ажиллагаатай хилийн боомтод албан томилолтоор ажиллах хугацаанд тэдэнд албан тушаалын сарын цалингийнх нь 15 хувиар бодож хилийн нэмэгдэл олгож байсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** — **М.ЭНХСАЙХАН**
**Сангийн сайд** — **П.ЦАГААН**

Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Гаалийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу гаалийн улсын байцаагчийн албан тушаал нь дор дурдсан зэрэг дэвтэй байна:

| Албан тушаалын ангилал | Албан тушаалын зэрэг дэв |
|---|---|
| Тэргүүн түшмэл | Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл<br>Дэд зэрэг тэргүүн түшмэл<br>Гутгаар зэрэг тэргүүн түшмэл<br>Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл |
| Эрхэлсэн түшмэл | Тэргүүн зэрэг эрхэлсэн түшмэл<br>Дэд зэрэг эрхэлсэн түшмэл<br>Гутгаар зэрэг эрхэлсэн түшмэл<br>Дөтгөөр зэрэг эрхэлсэн түшмэл |
| Ахлах түшмэл | Тэргүүн зэрэг ахлах түшмэл<br>Дэд зэрэг ахлах түшмэл<br>Гутгаар зэрэг ахлах түшмэл<br>Дөтгөөр зэрэг ахлах түшмэл |
| Дэс түшмэл | Тэргүүн зэрэг дэс түшмэл<br>Дэд зэрэг дэс түшмэл<br>Гутгаар зэрэг дэс түшмэл<br>Дөтгөөр зэрэг дэс түшмэл |
| Туслах түшмэл | Тэргүүн зэрэг туслах түшмэл<br>Дэд зэрэг туслах түшмэл<br>Гутгаар зэрэг туслах түшмэл<br>Дөтгөөр зэрэг туслах түшмэл |

2. Зэрэг дэвийг төрийн албанд нийт ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг харгалзан олгоно.

| Албан тушаалын ангилал /зэрэг дэв/ | Төрийн алба хаасан хугацаа /жилээр/ | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тухайн албан тушаалын ангилалд | Төрийн албанд | | | |
| | | Тэргүүн зэрэг | Дэд зэрэг | Гут-гаар зэрэг | Дөт-гөөр зэрэг |
| Тэргүүн түшмэл | | 25 ба түүнээс дээш | 23-24 | 21-22 | 19-20 |
| Эрхэлсэн түшмэл | | 20 ба түүнээс дээш | 18-20 | 14-17 | 10-13 |
| Ахлах түшмэл | | 15-аас дээш | 13-15 | 11-12 | 9-10 |
| Дэс түшмэл | 1 | 12-оос дээш | 10-12 | 7-9 | 4-6 |
| Туслах түшмэл | 2 | 8-аас дээш | 6-8 | 3-5 | 1-2 |

3. Төрийн албанд ажилласан нийт хугацаанд төрийн бүх төрлийн албан тушаалд ажилласан хугацааг оруулж тооцно.

4. Гаалийн улсын байцаагчид албан тушаалын зэрэг дэвийг олгохдоо төрийн албанд ажилласан нийт буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзана.

5. Зэрэг дэв олгох хугацаа болсон бөгөөд уг зэрэг дэв нь гаалийн улсын байцаагчийн тухайн албан тушаалд тохирч байгаа боловч түүний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин хангалтгүй нь үнэлгээгээр тогтоогдсон бол уг зэрэг дэвийг олгохгүй байж болно.

6. Зэрэг дэв бүхий гаалийн улсын байцаагчид сар бүр түүний албан тушаалын сарын цалингаас дор дурдсан хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл олгоно:

| Албан тушаалын ангилал | Зэрэг дэвийн нэмэгдэл /хувиар/ | | | |
|---|---|---|---|---|
| | Тэргүүн | Дэд | Гуттаар | Дөтгөөр |
| Тэргүүн түшмэл | 25 | 20 | 15 | 10 |
| Эрхэлсэн түшмэл | 25 | 20 | 15 | 10 |
| Ахлах түшмэл | 25 | 20 | 15 | 10 |
| Дэс түшмэл | 25 | 20 | 15 | 10 |
| Туслах түшмэл | 25 | 20 | 15 | 10 |

7. Гаалийн ажилд нарийн мэргэшин онцгой үр бүтээлтэй ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид энэ журмын 3 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө зэрэг дэв олгож болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл зэрэг дэвийг алгасуулан олгож болно.

8. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон буюу сахилгын шийтгэл хүлээж ажлаас халагдсан гаалийн улсын байцаагчийн зэрэг дэвийг түүний ажлаас халагдсан өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцно.

9. Сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажлын үр чадварын хувьд эрхэлсэн албан тушаалдаа тэнцэхгүй нь үнэлгээгээр тогтоогдсон тохиолдолд гаалийн улсын байцаагчийн зэрэг дэвийг бууруулж болно.

Харин тухайн албан тушаалд мэргэшлийн түвшингээрээ тэнцэж байгаа боловч албан тушаалын ангиллаас доогуур албан тушаалын ажилд өөрийн хүсэлтээр болон ажлын зайлшгүй шаардлагаар шилжин ажилласан гаалийн улсын байцаагчийн зэрэг дэвийг бууруулахгүй.

10. Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин болон ажлын үр чадварыг түүний шууд харьяалах дарга

үнэлж дүгнэх бөгөөд уг үнэлгээг дараагийн дээд шатны дарга хянаж батална.

Засгийн газрын 1997 оны 153 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИД ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн ажилтны төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын цалингаас доор дурдсан хувиар бодож олгоно:

| Төрийн алба хаасан хугацаа /жилээр/ | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/ |
|---|---|
| 5-12 | 10,0 |
| 13-20 | 15,0 |
| 21-25 | 20,0 |
| 26 ба түүнээс дээш | 25,0 |

3. Гаалийн улсын байцаагчийн төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулж тооцно:

а/төрийн албанд ажилласан;

б/ажиллаж байх хугацааныхаа дундуур мэргэжил дээшлүүлэх, шинээр мэргэжил эзэмших дамжаа болон магистрантур, аспирантур, докторонтурт суралцсан;

в/ажиллах хугацаандаа цэргийн албанд явсан, жирэмсэн, амаржсан болон хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл чөлөөтэй байсан;

г/байгууллагын дотоод дүрэмд заасны дагуу захиргааны чөлөөтэй байсан.

4. Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар нэмэгдэл олгох хувийг тогтоож байна.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 154 | Улаанбаатар хот

**Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих явдлыг журамлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих талаар гаргасан шийдвэрээ үзүүлж буй хөнгөлөлтийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоон өгөх чиглэлээр хянан үзэж өөрчлөхийн хамт төрөл бүрийн үнэмлэх, баримт бичиг үзүүлэн зорчих явдлыг зогсоох арга хэмжээ авахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөмж болгосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тахир дутуу иргэдэд зарим хөнгөлөлт үзүүлэх тухай" Засгийн газрын 1992 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 75 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн "б" заалтын "... аймгийн төв, хот суурин газрын нийтийн үйлчилгээний /таксинаас бусад/ тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй..." гэсэн хэсэг, "Мэргэжлийн сургуулийн оюутан, сурагчдад зарим хөнгөлөлт үзүүлэх тухай" Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 175 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — **М.ЭНХСАЙХАН**

Дэд бүтцийн хөгжлийн сайд — **Г.НЯМДАВАА**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 156 | Улаанбаатар хот

**Сургалтын байгууллагын бүтэц, ажиллагчдын орон тоог оновчтой болгох зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор сургалтын байгууллагуудын бүтэц, ажиллагчдын орон тоог оновчтой болгох цогц арга хэмжээг тухайн орон нутгийн нийгэм, эдийн засаг, хүн амын бодлого, тэдгээрийн хөгжлийн хандлага, хэрэгцээ, шаардлагатай нь уялдуулан 1997-1999 онд шат дараалалтай авч хэрэгжүүлэхийг Гэгээрлийн сайд Ч.Лхагважав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2.Сургалтын байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгосны үр дүнд хэмнэгдсэн хөрөнгийг тухайн сургууль, байгууллагад нь үлдээж сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа багш, ажиллагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд зарцуулахыг Сангийн сайд П.Цагаан, Гэгээрлийн сайд Ч.Лхагважав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3."Сургалтын байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгох, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тэтгэмж олгох журам"-ыг хавсралтаар баталж, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд П.Цагаан, Гэгээрлийн сайд Ч.Лхагважав, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд Л.Зориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** — М.ЭНХСАЙХАН

**Гэгээрлийн сайд** — Ч.ЛХАГВАЖАВ

**Сангийн сайд** — П.ЦАГААН

Засгийн газрын 1997 оны 156
дугаар тогтоолын хавсралт

# СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ОРОН ТООГ ОНОВЧТОЙ БОЛГОХ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

## Нийтлэг үндэслэл

Боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй "Боловсролын салбарын хөгжлийн бодлогын хөтөлбөр"-ийн (цаашид бодлогын хөтөлбөр гэнэ) хүрээнд сургалтын байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгох, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст* тэтгэмж олгоход энэхүү журмыг баримтална.

## Нэг. Бүтэц, орон тоог оновчтой болгох, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст тэтгэмж олгох ажлын удирдлага, зохион байгуулалт

1.1."Бодлогын хөтөлбөр"-ийн хүрээнд сургалтын байгууллагуудын бүтэц, орон тоо (цаашид бүтэц, орон тоо гэнэ)-г оновчтой болгох, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст тэтгэмж олгох ажлыг улсын хэмжээнд Гэгээрлийн яам, Сангийн яам хамтран удирдан зохицуулна.

1.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн бүтэц, орон тоог оновчтой болгох, ажиллагчдын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст тэтгэмж олгох асуудлыг тухайн шатны Засаг даргын захирамжаар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (цаашид мэргэжлийн сургууль гэнэ)-д тус сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд тус тус удирдан зохицуулна.

*Тайлбар : *Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүс гэдэгт улсын төсвөөс цалин авахгүйгээр өмчийн олон хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад ажиллах болон хувиараа хөдөлмөр эрхлэх хүмүүсийг хамруулан ойлгоно.*

1.3.Сум, дүүргийн ажлын хэсэг өөрийн нутаг дэвсгэрийн сургалтын байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгох хувилбаруудыг боловсруулан, хамгийн

ур авъгтайг нь сонгон авахын сацуу илүүдэлтэй болон дутуу орон тоог байгууллага нэг бүрээр тогтооно. Илүүдэлтэй орон тоон дээр ажиллаж байгаа хүмүүст ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд эдлэх эрх, үүргийн талаар танилцуулна.

1.4.Сум, дүүргийн болон мэргэжлийн сургуулийн ажлын хэсэг дээд шатны ажлын хэсгээс ирүүлсэн аливаа мэдээлэл, зөвлөмжийн талаар сургалтын байгууллагуудын хамт олонд мэдээлэхийн хамт ажлаас чөлөөлөгдөх хүмүүст тэтгэмж олгох бэлтгэл ажлыг зохион байгуулна.

1.5.Бодлогын хөтөлбөрийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийг хөдөлмөр зохицуулалтын алба тусгайлан бүртгэн авч, аль нэг төсөвт байгууллагад хөдөлмөр эрхлэхгүй байхаар гэрээ байгуулсан 3 жилийн хугацаанд нь тэднийг ажилгүйчүүдийн тоонд оруулахгүй.

## Хоёр.Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст тэтгэмж олгох

2.1.1997 оны 1 дүгээр сарын 1-нд бэлэн байсан тухайн сургалтын байгууллагын орон тоог "Бодлогын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үндэс болгоно.

2.2.Бүтэц, орон тоог оновчтой болгох явцад ажлын байр нь илүүдэлтэй байгаа нь тогтоогдож ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст "Бодлогын хөтөлбөр"-ийн ээлийн хөрөнгийн санхүүжилтээс тэдний ажилласан хугацааг харгалзан нэг удаагийн тэтгэмж олгоно.

2.3.Сум, дүүргийн болон мэргэжлийн сургуулийн ажлын хэсэг нь ажлын байрны илүүдлээс шалтгаалан ажлаас чөлөөлөгдөх шийдвэр гарсан хүмүүсийн улсад ажилласан нийт хугацаа (цэргийн алба хаасан, сургуульд суралцсанаас бусад хугацаа орно) болон сарын үндсэн цалингийн хэмжээг Засгийн газрын 1997 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн жишиг"-ийн дагуу сургалтын холбогдох байгууллага ба нэгжээр гаргуулж баталгаажуулна.

2.4.Ажлаас чөлөөлөгдөх хүнд олгох тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо энэхүү журмын 1 дүгээр хавсралтыг үндэс болгоно.

2.5.Тэтгэвэрт гарахад 3 хүртэл жил дутуу байгаа боловч ажлын байр нь илүүдэлтэй нь тогтоогдсон нөхцөлд зөвхөн тэтгэвэрт гарах хүртэлх хугацааны цалингийн жишигтэй тэнцэх тэтгэмжийг олгоно. Хэрэв

3 буюу түүнээс дээш жил дутуу бол гурван жилийн цалингийн хэмжээтэй тэнцэх тэтгэмжийг олгоно.

2.6.Ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмжийг тогтоосны дараа энэ тухайгаа сум, дүүргийн болон мэргэжлийн сургуулийн ажлын хэсэг хүн бүрт танилцуулна.

2.7.Авах тэтгэмжийнхээ хэмжээг мэдсэний дараа ажлаас чөлөөлөгдөх хүн банкинд хадгаламжийн дэвтэр нээлгэнэ.

2.8.Ажлаас чөлөөлөгдөх хүн бүртэй 2 дугаар хавсралтын дагуу гэрээ байгуулж, түүнийг 5 хувь үйлдэнэ. Гэрээний хувийг ажлаас чөлөөлөгдсөн хүнд, бусад хувийг нь тухайн сургууль, сум, дүүрэг, аймаг (нийслэл)-ийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс болон хөдөлмөр зохицуулалтын албанд тус тус хүргүүлнэ.

2.9.Сум, дүүргийн болон мэргэжлийн сургуулийн ажлын хэсэг илүүдэлтэй ажлын байр болон ажлаас чөлөөлөгдөх хүмүүсийн нэгдсэн судалгаар 1998,1999 онд тухайн жилийн 5 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн болон Гэгээрлийн яамны ажлын хэсэгт ирүүлнэ. Судалгаанд холбогдох хүснэгтийг Гэгээрлийн яамнаас гаргаж мөрдүүлнэ.

4.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, дотоод, гадаадын аливаа аж ахуйн нэгжээс эд хөрөнгийг хувьчлуулахаар санал ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороо, тухайн эд хөрөнгө түүнийг одоогоор эзэмшиж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай эсэх, түүнээс салган хувьчилж болох эсэхийг тодорхойлно.

5.Тухайн эд хөрөнгийг салган хувьчилж болох эсэхийг тодорхойлохдоо түүнийг одоо эзэмшиж буй хуулийн этгээдийн саналыг харгалзан үзнэ. Уг саналд дараах мэдээллийг заавал тусгасан байна:

а)эд хөрөнгийн дэлгэрэнгүй тодорхойлолт, танилцуулга;

б) эд хөрөнгийн элэгдлийг тооцсон тайлан тэнцэлийн үлдэгдэл өртөг;

в)тухайн эд хөрөнгийг эзэмшигч хуулийн этгээд одоо хэрхэн ашиглаж байгаа тухай танилцуулга;

г)эд хөрөнгийг салгаж хувьчилсан тохиолдолд одоо эзэмшиж буй хуулийн этгээдэд учирч болох хохирлын тооцоо.

6. Дээрх мэдээллийг 14 хоногийн хугацаанд Төрийн өмчийн хороонд гаргаж өгөх бөгөөд уг мэдээллийг үндэслэн Төрийн өмчийн хороо хувьчлах шийдвэрийг гаргана. Хувьчлах шийдвэр гаргасан тохиолдолд эд хөрөнгийн доод үнийг тогтоож, нийтийн дуудлагын худалдаа зохион байгуулна.

7.Дуудлагын худалдаанаас олсон орлогыг улсын төсөв болон эзэмшиж байсан хуулийн этгээдийн хооронд тэнцүү хэмжээгээр хуваарилна.

8.Хэрэв тухайн эд хөрөнгийг эзэмшиж байсан этгээд зориудаар буруу ташаа мэдээлэл өгсөн тохиолдолд тухайн эд хөрөнгийн хувьчлалын орлогоос хувь хүртэх эрхээ алдана.

**Найм. ДАХИН ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАГДААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖИЙГ ХУВЬЧЛАХ ЖУРАМ**

1.Дахин дуудлагын худалдаанд оруулахад худалдах доод үнэтэй тэнцүү буюу түүнээс дээш үнийн санал ирээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн орол-

цоотой аж ахуйн нэгжийг хувьчлахад энэхүү журмыг мөрдөнө.

2.Харьцангуй бага үнэтэй нөхцөлөөр дахин дуудлагын худалдаанд оруулахад худалдагдаагүй үлдсэн аж ахуйн нэгжийг дараахь хоёр төрөлд ангилж үзнэ:

а) тухайн аж ахуйн нэгж өргүй буюу бага өртэй;

б) тухайн аж ахуйн нэгж цаашдаа ажиллах ирээдүйтэй боловч их өртэй.

3. Өргүй боловч хөрөнгө оруулагчдын сонирхол татаагүй, ямар ч үнэ цэнэгүй болох нь зах зээлийн эрэлтээр тогтоогдсон энэхүү журмын 2-ын "а"-д дурдсан аж ахуйн нэгжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дампууруулах буюу татан буулгана.

4.Дахин дуудлагын худалдаагаар худалдагдаагүй аж ахуйн нэгжийн өр зээлийн хэмжээ тухайн аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоог 300000-аар үржүүлсэнтэй тэнцэх үнийн дүнгээс их байвал энэхүү журмын 2-ын "б" ангилалд оруулна.

5.Өртэй аж ахуйн нэгжийн өрийг зохих журмаар шийдвэрлэсэн тохиолдолд хувьчлагдан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллах боломжтой аж ахуйн нэгжийг татан буулгалгүйгээр өрийг нь хувьцаагаар солих аргыг хэрэглэж хувьчилна. Ингэхдээ 100 төгрөгийн тайлан тэнцлийн өртөг бүхий өр 100 төгрөгийн нэрлэсэн өртөг бүхий хувьцаатай тэнцүү гэсэн томъёоллоор тухайн аж ахуйн нэгжийн нийт өрийн хэмжээгээр шинээр хувьцаа гаргаж солино.

6.Өр зээлийг хувьцаагаар сольсноор тухайн аж ахуйн нэгж өргүй болж, өрийг хувьцаагаар сольж авсан зээлдүүлэгч эзэд өмчлөгч болно.

7.Нийт зээлдүүлэгчид нь хувийн өмчит аж ахуйн нэгж, хувь хүн байвал өр зээлийг хувьцаагаар сольсноор тухайн аж ахуйн нэгж хувьчлагдсанд тооцно.

8.Зарим зээлдүүлэгчид нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, банк байх тохиолдолд хувьчлалыг бүрэн гүйцэж дуусгахын тулд дараахь арга хэмжээг авна:

а)өрийг хувьцаагаар сольсноор үүссэн нийт хувьцаа эзэмшигчдээ хувийн болон төрийн гэж хоёр хуваах;

б)төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн нийт хувьцааг нэг багц болгон дахин дуудлагын худалдаагаар худалдах.

9.Өрийг хувьцаагаар сольсноор үүссэн төрийн өмчийн хувьцааг дуудлагын худалдаагаар хувьчилснаас олох орлогыг хувьцаа эзэмшигч төрийн өмчийн болон

төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудад хувь тэнцүүлэн хуваарилж, өрийг барагдуулсанд тооцно.

### Хс. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН СОНИРХЛЫГ ТАТАХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ ХУВЬЧЛАХАД ЗӨВЛӨХ, ЗУУЧЛАГЧИЙГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

1.Энэ журмаар хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц аж ахуйн нэгжийг хувьчлахад зөвлөх, зуучлагчийг ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2.Хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц аж ахуйн нэгжүүдийг хувьчлахад зөвлөх, зуучлах үүрэгтэй хөрөнгө оруулалтын банк, зөвлөлгөө өгөх компанийн төлөөлөгч (цаашид зөвлөх, зуучлагч гэнэ)-ийг хөлсөөр ажиллуулж болно.

3.Хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах аж ахуйн нэгжийг хувьчлахад зөвлөх дараахь туслалцаа үзүүлнэ:

а/хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц аж ахуйн нэгжүүдийн талаархи мэдээлэл бэлтгэж боловсруулан аль болох өргөн хүрээнд чөлөөтэй хүргэж сурталчлах;

б/тодорхой аж ахуйн нэгжийг сонирхох хөрөнгө оруулагчдыг судлах.

4.Хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц компанийг хувьчлахад зөвлөх, зуучлагчдын дунд чөлөөтэй оролцох боломжтой тендерийг холбогдох яамны албан ёсны саналыг тусган Төрийн өмчийн хороо зарлана.

5.Төрийн өмчийн хороо нь Монгол Улсын Засгийн газрын хувьчлалын хөтөлбөртэй уялдуулан гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах боломжтой гэж үзэж буй зарим аж ахуйн нэгжийн талаархи товч мэдээллийг багтаасан танилцуулга бэлтгэж тендерт оролцож болох зөвлөхүүдэд явуулна. Уг танилцуулгад тендер дүгнэхэд ашиглах аргыг нарийвчлан тайлбарлана.

6.Зөвлөхүүдэд тендерт оролцох саналаа бэлтгэх боломжийг олгохын тулд 60-аас доошгүй хоногийн өмнө тендерийг зарлана.

7.Тендерт оролцогчдоос ирүүлэх саналд дараахь мэдээллийг тусгасан байна:

а) Монгол Улстай ижил төстэй орнуудад хувьчлалын зөвлөлгөө өгч байсан ажлын туршлага;

б)зөвлөх, зуучлагчийн Төрийн өмчийн хороо болон хөрөнгө оруулагчтай хийх гэрээний төсөл, төлбөрийн нөхцөл;

в)зөвлөх, зуучлагчийн ажлаа хэрхэн зохион байгуулах төлөвлөгөө.

8.Төрийн өмчийн хороо нь тендерт ирүүлсэн зөвлөх, зуучлагчдын саналуудыг дараахь зарчмаар шалгаруулна:

а)хувьчлалын асуудлаар зөвлөлгөө өгөх, зуучлах ажлын зохих түвшний туршлага дутмаг болон өмнө нь энэ асуудлаар алдаа гаргаж байсан нь тогтоогдсон зөвлөхүүдийн саналыг хасах;

б)зөвлөх, зуучлагчийн санал болгосон өртгийн үнэмлэхүй хэмжээг харгалзан үзэх.

9.Тендер шалгаруулахад дараахь ерөнхий зарчим баримтална:

а)хувьчлалын үр дүнд орох орлого, үр дүнтэй холбоотой байх төлбөрийн нөхцөлийг чухалчлах;

б)зөвлөх, зуучлагчид хөрөнгө оруулагчдаас аливаа төлбөр авахгүй байх нөхцөлийг хангах;

в)зөвлөх, зуучлагчид бага орлогоос аль болох бага төлбөр авах, орлого нэмэгдэх тутам төлбөрийн хувь, хэмжээг багаар нэмэгдүүлэх;

г)үлэмж их хэмжээний орлого оруулсан тохиолдолд зөвлөх, зуучлагчийн авах шимтгэл их хэмжээтэй байж болохыг хүлээн зөвшөөрөх;

д)зөвлөх, зуучлагчдад тухайн объектыг аль болох хурдан худалдах сонирхол төрүүлэх;

е)зөвлөх, зуучлагчид тухайн аж ахуйн нэгжийн хувьцаагаар төлбөрөө авахыг зөвшөөрөх.

10.Төрийн өмчийн хороо санал ирүүлэх сүүлчийн өдрөөс хойш 10 хоногийн дотор эцсийн сонголтыг хийнэ.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр　　Дугаар 162　　Улаанбаатар хот

**Хилийн заагийг тогтоох тухай**

"Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай" Монгол Улсын Их Хурлын 1997 оны 47 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хөгнөхаан уулын байгалийн нөөц газрын хилийн заагийг хавсралтын ёсоор тогтоосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд　　М.ЭНХСАЙХАН**

**Байгаль орчны сайд　　Ц.АДЪЯАСҮРЭН**

Засгийн газрын 1997 оны 162 дугаар тогтоолын хавсралт

## ХӨГНӨХААН УУЛЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Баян-уул, түүнээс зүүн хойш орших Хөшөөт толгой /1246,8/, Мухарын даваа, Мухарын даваанаас зүүн урагш орших Хамар даваа, түүнээс зүүн тийш орших Урд ендор, Холбоо толгой,Гэр даваа, Гэр даваанаас зүүн урагш орших Шамбын гозгор /1386,2/, түүнээс баруун урагш орших Ганьдгаарт /1386,5/, Угалз толгой, 1462,0 тоот, 1462,0 тоотоос урагш хадан хошууны зүүн талд орших шон №1, түүнээс баруун урагш орших Тойн цохио, Луу толгой, Таван цохионы баруун талд Шилүүт голын хойт эрэг дээр орших шон №2, түүнээс баруун хойш Шилүүт голын зүүн эргээр уруудан Шилүүт, Тарнайн голын бэлчир, тэндээс баруун хойш Тарнайн голын зүүн эргээр уруудан 1153,0 тоот, түүнээс зүүн хойш орших Баян-уул.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 164 | Улаанбаатар хот

**Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар батлсугай:

а/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар;

б/Төрийн захиргааны удирдлагын газар;

в/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

г/Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "е" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** — **М.ЭНХСАЙХАН**

**Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд** — **Л.ЗОРИГ**

Засгийн газрын 1997 оны 164 дүгээр
тогтоолын хавсралт

## ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### *I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ*

### *1.1. Оршил*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-т Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

### *1.2. Үндэслэл*

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн *"Монгол Улсын тэргүүн Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн үндсэн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"*-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн *"Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"*, "Засгийн газрын Удирдлагын онолын хөтөлбөрийн *"Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл"* зөвлөх хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан *"Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлт загвар"* төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

### *1.3. Хууль тогтоомжийн орчин*

Хөтөлбөрийг доор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- **Монгол Улсын Үндсэн хууль;**
- **Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;**
- **Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;**
- **Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;**
- **Монгол Улсын Эрүүлийг хамгаалах хууль;**
- **Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай Монгол Улсын хууль;**
- **Нийгмийн даатгалын тухай Монгол Улсын хууль /багц/;**
- **Нийгмийн халамжийн тухай Монгол Улсын хууль /багц/;**
- **Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хууль;**
- **Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль;**
- **Бусад холбогдох хууль тогтоомж.**

### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Чиглэлийн яамдын нэг болох Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь салбарын бодлого, төлөвлөлтийн болон бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь Засгийн газрын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

### 1.6. Стратегийн удирдлага, зохион байгуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт доор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын танхим байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал) - ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

### *2. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ*

#### *2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

#### *2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлж, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын танхимд үзүүлэх зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэгийн үр дүнг сайжруулах;
2. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн, боловсронгуй болгох;
3. Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаа тогтоож, хувийн хэвшлийг бүх талаар дэмжин хөгжүүлэх;
4. Иргэдийг эрүүл мэндээ хамгаалах, бэхжүүлэх, хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах арга зүйд сургах, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалах.

#### *2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго*

**ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО**

***Монгол Улсын хүн ам эрүүл өсч хөгжих, бүтээлчээр хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нийгмийн хамгаалал, халамжийн зохистой нөхцөл бүрдүүлэх***

### *2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн доор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад цаг үеэ олсон зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэх;

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

4. Хүн ам, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх.

### *2.5. Үйл ажиллагааны гол зорилт*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн доор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

*1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:*

*1.1. Хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэх;*

*1.2. Хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хөтөлбөр, төсөл боловсруулахад мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;*

*2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:*

*2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, сайд болон аппарат шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон дотоод дэмжлэг үзүүлэх;*

*2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;*

*2.3. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг хүний нөөцийн удирдлагаар хангах.*

*3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:*

*3.1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлогын хэрэгжилт, нийгмийн бол[…] мэргэжлийн өрөө хэмжээг зохицуулах;*

*3.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт болон халам[ж] асрамж, үйлчилгээний өргөө хэмжээг зохицуулахад зөвлөлгөө өгөх, бүх тал[ын] дэмжлэг үзүүлэх;*

*3.3. Хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын газ[ар] хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэ[х]*

*4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:*

*4.1. Хүн ам, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөр, төсөл, норм, норматив, стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнг үнэлэх;*

*4.2. Хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, нөөц илрүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх;*

*4.3. Хүн ам, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн сан, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.*

### *2.6. Үйл ажиллагааны зорилт*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус нам тодорхойлж хэрэгжүүлнэ.

### *2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг доор дурдсанаар тодорхойлж байна.

## ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



## 3. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, САНАЛ БОЛГОЖ БУЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

### 3.1. *Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад доор дурдсан зарчим баримтлав.

1. *Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим* (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх).

2. *Эрх мэдлийн ялгаа заг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим* (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх).

3. *Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим* (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, тухайн яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь яамны үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).

4. *Бүтцийн хувьд энгийн байх зарчим* (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн (3-аас илүүгүй) шат дамжлагатай байх).

5. *Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим* (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой биелүүлэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үүрэг хариуцлагыг жигд хуваарилах боломжийг бүрдүүлсэн байх).

6. *Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим* (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үйлчилгээ үзүүлж байх).

7. *Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим* (бүтцийн ерөнхий загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

### *3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар*

Дээр дурдсан зарчим болон Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн доор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

**ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР**




### *3.3. Зохион байгуулалтын бүтэц*

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны доор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

**1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого,

төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, хүн амын бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын урт, дунд болон хугацааны стратегийн төлөвлөлөө, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр, төсөл боловсруулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар эрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газар (танхим) байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон эвсэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

**2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг ерөнхий туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлын тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цөөхөн, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэжсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын ур чадварыг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэжлийн ур чадварыг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон

хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд бусад хэрэглэгч байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний болон гадаад орон, олон улсын байгууллага байна.

### 3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд энэ нэгж нь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, нийгмийн болон мэргэжлийн тэрчлэн халамж, асрамж, үйлчилгээний арга хэмжээг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь бодлого, төсвийн тэнцвэрт байдал харилцан уялдаа холбоог хангахад, Засгийн газар, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах, зохион байгуулан хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газрууд, аж ахуйн нэгж, ард иргэд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын түүнчлэн олон улсын болон төрийн бус зарим байгууллага байна.

### 4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, норм, норматив, стандартын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтг

албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд энэ үйлчилгээг шууд бус хэлбэрээр хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 165 | Улаанбаатар хот |

**Хувьчлах объектын жагсаалт батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг болон 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дуудлагын худалдаагаар хувьчлах барилга байгууламж, дуусаагүй барилгын жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Халдварт өвчин судлалын төвийн барилгыг эмнэлгийн зориулалтаар ашиглуулахаар хязгаартай дуудлага худалдаагаар, бусад объектуудыг нийтийн дуудлага худалдаагаар 1997 оны III улиралд багтаан хувьчлах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдод даалгасугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **М.ЭНХСАЙХАН** |
| **Сангийн сайд** | **П.ЦАГААН** |

Засгийн газрын 1997 оны 165 дугаар тогтоолын хавсралт

**ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУВЬЧЛАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДУУСААГҮЙ БАРИЛГЫН ЖАГСААЛТ**

| № | Аймаг, хотын нэр | Үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр | Түрээсээр эзэмшиж буй аж ахуйн нэгжийн нэр | Хувьчлах барилга байгууламжийн нэр |
|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Улаанбаатар | Налайх дүүргийн ОСНАА-н газар | "Их тэнгис интер-нэйшнль" компани | ОСНААГ-ын контор байсан 2 давхар хуучин барилга |
| 2 | Улаанбаатар | Баянгол дүүргийн ОСНАА-н 14 дүгээр контор | | ОСНАА-н 14 дүгээр конторын дэргэдэх дуусаагүй барилга |
| 3 | Улаанбаатар | Сэргээгдэх эрчим хүчний хүрээлэн | Ашиглалтгүй байгаа | Төмөр бетон заводын (хуучин нэрээр) ашиглагдахгүй бай-гаа хуучин барилга |
| 4 | Улаанбаатар | Дэд бүтцийн хөгжлийн яамны дэргэдэх Авто тээврийн газар | | Меркурий худалдааны төвийн барилга |
| 5 | Улаанбаатар | МУИС | | Цайз захын баруун хойд талд байдаг агуулахын 4 барилга |
| 6 | Улаанбаатар | Вийслэлийн өмчийн газар | "Жаран" ХХК | Аж үйлдвэрийн барааны 45 дугаар дэлгүүрийн (хуучин нэрээр) контор, ариун цэврийн өрөө |
| 7 | Улаанбаатар | Чингэлтэй дүүргийн ОСНАА-н 2 дугаар контор | "Мандах-цог" ХХК | Ялалт кино театрын ар талын "Мандах-цог" ХХК-ны түрээсээр эзэмшиж байгаа барилга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | Улаанбаатар | Эх нялхсын эрдэм шинжилгээний төв | | Хүүхдийн больниц (хуучин нэрээр)-ын барилга |
| [illegible] | Улаанбаатар | Халдварт өвчин судлалын төв | | Халдварт өвчин судлалын төв байрлаж байсан барилга |
| 0 | Улаанбаатар | Улсын аюулгүй байдлыг хангах газар | | Музейн барилга |
| 1 | Улаанбаатар | Улсын цирк | | Хуучин циркийн дугана барилга |
| 2 | Улаанбаатар | "Авто-импэкс"ХК | | Амгалан дахь нөөцийн агуулахын барилга |
| 3 | Улаанбаатар | Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Бага тэнгэрийн захиргаа | | Барилга байгууламжууд |
| 4 | Улаанбаатар | Чингэлтэй дүүргийн ОСНАА-н 16 дугаар конторын 7 дугаар байр | "Монпольрайд" ББ нөхөрлөл | ОСНАА-н 16 дугаар конторын харьяа YП байрын I давхрын "Монпольрайд" ББ нөхөрлөлийн түрээсээр эзэмшиж буй байр |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар сарын 16-ны өдөр — Дугаар 166 — Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Улсын байнгын онцгой комиссын дүрэм"-ийг хавсралтын ёсоор шинэчлэн батлсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын байнгын онцгой комиссын бүрэлдэхүүн,дүрмийг шинэчлэн

батлах тухай" Засгийн газрын 1993 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 97 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

Батлан хамгаалахын сайд Д.ДОРЛИГЖАВ

Засгийн газрын 1997 оны 166 дугаар тогтоолын хавсралт

## УЛСЫН БАЙНГЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг /газар хөдлөлт, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг/ тохиолдсон, үйлдвэрлэлийн томоохон осол болсон, цацраг идэвхт буюу хүчтэй үйлчилгээтэй хорт бодис алдагдсан, эсвэл тэдгээрээс хүн ам, мал, байгаль орчинд аюултай байдал, бохиртол үүссэн /цаашид "гамшиг, осол" гэнэ/-ий улмаас учруулсан хор уршгийг арилгах, аврах, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, сэргээн босгох, бусад хойшлуулшгүй арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бүс нутгийн хүч хүрэлцэхгүй болж тусламж, дэмжлэг үзүүлэх талаар тэдгээрийн удирдлагаас албан ёсны хүсэлт тавьсан үед Улсын байнгын онцгой комиссоос хүн хүч, техник хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг удирдан зохион байгуулахад энэ дүрмийг дагаж мөрдөнө.

2.Улсын байнгын онцгой комисс /цаашид "комисс" гэнэ/-ын бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Комиссыг Засгийн газрын гишүүн, сайд тэргүүлнэ.

3.Комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хамгаалалтын тухай хууль, бусад холбогдох хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн зохих эрхийн актыг мөрдлөг болгоно.

4.Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх алба нь Улсын иргэний хамгаалалтын газар байна.

5.Комисс нь зохих хууль тогтоомж, энэ дүрмээр олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдо

асуудлыг хурлаараа хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол, протокол, албан даалгавар гаргана. Комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулахтай холбогдсон хөрөнгө захиран зарцуулах эрх зүйн акт нь комиссын дарга /орлогч/-ын тушаал байна.

6.Комиссоос эрх хэмжээнийхээ дагуу гаргасан шийдвэрийг төв, орон нутгийн төрийн захиргааны бүх шатны холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд дагаж мөрдөх үүрэгтэй.

7.Комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**Хоёр.Комиссын үүрэг, эрх**

8.Комисс дараахь үүрэг гүйцэтгэнэ:

а/гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны төв, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх;

б/гамшиг, ослын цагийн байдал, нөхцөлд мэргэжлийн холбогдох байгууллага, албадтай хамтран үнэлэлт, дүгнэлт өгч тухайн засаг захиргаа, бүс нутгийн хүч хэрэгслээр уг гамшиг, ослыг арилгах боломжгүй болох нь нотлогдсон үед хүн хүч, техник хэрэгслийг хугацаа алдалгүй дайчлан гаргаж учруулсан хор уршгийг арилгах, аврах, хамгаалах арга хэмжээ авах, нэрвэгдэгсэдэд тусламж үзүүлэх ажлыг шуурхай зохицуулан зохион байгуулах замаар тус улсын хүн ам, нийгэм, эдийн засгийг хохирол, сүйрлээс хамгаалах;

в/гамшиг, ослын үед дайчлан гаргах хүн хүч, техник хэрэгслийн байршил, бүрэлдэхүүн, хангалт, тэдгээрийн бэлэн байдлыг байнгын хяналтдаа байлгах, Улсын иргэний хамгаалалтын газар, төрийн захиргааны төв, орон нутгийн холбогдох байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргаар шаардлагатай арга хэмжээг авахуулж байх;

г/гамшиг, ослын голомтод ажиллагсдын ажиллах журмыг тухайн нөхцөл, байдалтай уялдуулан тогтоон өгч хэрэгжилтийн явцад хяналт тавих;

д/гамшиг, ослын үед учруулсан хор уршгийг арилгах, аврах, хамгаалах, нэрвэгдэгсэдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, тээврийн болон холбооны хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах асуудлыг төв, орон нутгийн засаг захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтантай

хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулж шийдвэрлүүлэх;

е/гамшиг, осол бүхий нутаг дэвсгэр, бүс нутаг, аж ахуйн нэгж, байгууллагад хорио цээр, дэглэм тогтоох талаар санал боловсруулж зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

ж/гамшиг, осолтой тэмцэх асуудлаар эрх хэмжээнийхээ хүрээнд зохих хууль тогтоомжийн дагуу гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, тэдний арга туршлагыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

з/комиссын орон тооны ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал гаргах.

9.Комисс дараахь эрхтэй байна:

а/гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангах, учруулсан хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, даалгавар өгч биелэлтийг нь хангуулах, хяналт тавих;

б/гамшиг, осол бүхий нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээр, дэглэмийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг батлан гаргаж, биелэлтийг хангуулах;

в/гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангах, учруулсан хор уршгийг арилгах, хөрөнгө захиран зарцуулах зэрэг асуудлыг холбогдох төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжид шалгаж шаардлагатай арга хэмжээг авахуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт, чиглэл өгөх, эрх баригчдынх нь мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах;

г/гамшиг, осолд нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хамгаалах, учруулсан хор уршгийг арилгах, сэргээн босгох ажилд шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эм тариа, хүнсний болон бусад бараа материал, хөрөнгө зэргийг улсын нөөцөөс гаргуулах тухай асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

д/гамшиг, ослын хор уршгийг арилгах, шалтгааныг тогтоох ажилд мэргэжлийн холбогдох байгууллага, албан тушаалтан, хүмүүсийг татан оролцуулах, тэд-

нээр шаардагдах судалгаа, дүгнэлт, материалыг гаргуулан авах;

е/гамшиг, ослын тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохих хууль тогтоомж, эрх хэмжээнийхээ хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгох, боловсронгуй болгох, бусад асуудлыг шийдвэрлэх;

ж/шаардлагатай гэж үзвэл гамшиг, ослын бүс нутаг, байгууламжийг харьяалдаг аймаг, нийслэлийн Засаг даргыг Улсын байнгын онцгой комиссын бүрэлдэхүүнд оруулан ажиллуулах шийдвэр гаргах.

**Гурав.Орон нутгийн байнгын онцгой комисс**

10.Аймаг, нийслэл, сум, дүүргийн байнгын онцгой комиссын бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга, дүрмийг аймаг, нийслэлийн Засаг дарга батлах бөгөөд комиссын өдөр тутмын үйл ажиллагааг цэрэг, иргэний хамгаалалтын штаб, ажилтан эрхэлнэ.Тухайн шатны байнгын онцгой комиссын дарга нь Засаг дарга байна.

11.Аймаг, нийслэлийн комисс нь нутаг дэвсгэртээ гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хамгаалах, учруулсан хор уршгийг арилгах арга хэмжээг хариуцан зохион байгуулах, энэ талаар шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, дээд шатны комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг зохион байгуулах үүрэгтэй ажиллана.

12.Аймаг, нийслэлийн комисс нь энэ дүрмийн 8,9 дүгээр зүйлд заасан эрх, үүргийн өөрийн эрх хэмжээнд хамаарах хэсгийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлнэ.

13.Аймаг, нийслэл, сум, дүүргийн комисс нь нутаг дэвсгэртээ гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангах, учруулсан хор уршгийг арилгахтай холбогдсон хөрөнгө, зардлыг жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу, зориулалтаар нь захиран зарцуулна.

14.Аймаг, нийслэлийн комисс нь гамшиг, ослоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх бэлтгэлийг хангах, учруулсан хор уршгийг арилгах талаар зохиосон ажил, үр дүнг Улсын байнгын онцгой комисст тогтоосон журмын дагуу тайлагнана.

**Дөрөв. Комиссын хөрөнгө, түүнийг захиран зарцуулах**

15.Комисс нь өөрийн мэдлийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй байна.

16.Комиссын хөрөнгө, санхүү нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/төв, орон нутгийн төсвөөс эрх бүхий байгууллагын шийдвэрээр комиссын мэдэлд шилжүүлсэн мөнгө, хөрөнгө;

б/гадаад орон, олон улсын байгууллага, иргэд, түүнчлэн дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламжийн мөнгө, хөрөнгө.

17.Төв, орон нутгийн байнгын комиссын мэдэлд мөнгө, хөрөнгө шилжүүлэн өгөх тухай шийдвэрийг холбогдох шатны комиссоос оруулсан саналыг үндэслэн Засгийн газар /тухайн Засаг дарга/ гаргана.

18.Комисс нь энэ дүрмийн 16 дугаар зүйлд заасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр байгуулсан сантай байж болно. Сангийн валют, төгрөгийг тус бүр нэг дансанд төвлөрүүлнэ.

19.Комисс нь өөрийн мэдлийн хөрөнгө, санг тодорхой зориулалтаар болон үйл ажиллагаагаа санхүүжүүлэхээр захиран зарцуулах эрхтэй.

20.Комиссын мэдлийн хөрөнгийг олгогдсон эрх хэмжээнийхээ дагуу комиссын дарга, орлогч нар захиран зарцуулах эрх эдэлнэ. "Улсын байнгын онцгой комиссын мэдлийн хөрөнгийг захиран зарцуулах журам"-ыг комиссын хурлаар батлан мөрдүүлнэ.

21.Комиссын мэдлийн хөрөнгө, сангийн ашиглалт, зарцуулалтын байдлыг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган хагас, бүтэн жилээр баланс гаргана.

## Тав.Бусад зүйл

22.Комисс нь үйл ажиллагааныхаа тайлан, хөрөнгө санхүүгийн балансаа хурлаараа хэлэлцэн дүгнэж байх бөгөөд, ажлынхаа тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт оруулна.

23.Комисс нь өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй болон хөрөнгө, санг захиран зарцуулах журмыг зөрчсөн албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулах тухай саналаа холбогдох эрх бүхий албан тушаалтан, байцаагчид тавина.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

| | |
|---|---|
| Ерөнхий эрхлэгч | **Л. Цог** |
| Хариуцлагатай нарийн бичгийн дарга | **Б. Ганбат** |
| Гишүүд: | **Б. Бадамханд**<br>**Ч. Дашням**<br>**Б. Цэнддоо**<br>**Б. Чимид**<br>**Б. Энэбиш** |
| Техник редактор | **С. Итгэлт** |
| Уншиж хянасан | **Сан. Жаргалсайхан**<br>**Б. Янжинлхам** |

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 8-р сарын 2-нд. Өрөлтөд 1997 оны 8-р сарын 26-нд. Хэвлэлтэд 1997 оны 9-р сарын 18-нд. Хэвлэлийн хуудас 8. Хэвлэсэн тоо 3820 ш.

**Манай хаяг:** Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

**Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг**
**Эрхлэх Газрын харьяа**
**Хэвлэх үйлдвэр**